БОЛОВСРОЛЫН
СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

# СӨБ, ЕБС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХҮРЭЭ

# СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ОДОО
















“Нийт хүүхэд” → “Хүүхэд бүрийн хөгжил”

ЦААШИД
















“……………………………………” → “……………………………………”

# СУРАЛЦАГЧИЙН ДҮР ТӨРХ, ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ







**Онолын загвар, концепц**

**Нийгэм болон хувь хүний хэрэгцээ, шаардлага**

**Дэлхийн болон үндэсний өв соёлыг өвлөн эзэмшдэг, эх дэлхийгээ хайрлан хамгаалдаг, аливаа асуудлыг шүүн тунгааж, бүтээлчээр шийдвэрлэдэг, хариуцлагатайгаар хамтран ажилладаг, ёс суртахуунтай, эрүүл, насан туршдаа суралцах чадвартай иргэнийг хөгжүүлэх**

**Соёл, уламжлал**

**Олон улсын чиг хандлага**






# СУРАЛЦАГЧИЙН ШИНЖ БА ЧАДАМЖ



# ЧАДАМЖ БА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| *Нээлттэй сэтгэгч* | *Бүтээлч сэтгэхүй* | *Бүтээлч байдалд бэлдэх* | *Олон төрлийн бүтээлч үйл ажиллагаанд оролцох* | Өгүүллэг, үлгэр сонсоод дүрд тоглох, уран сэтгэмждээ буулгах | Уран сэтгэмжээ илэрхийлэх үйл ажиллагаанд оролцох | Хэл зохиол, урлаг, соёлын бүтээлч ажилд оролцох | Урлаг, соёлын гэх мэт бүтээлч цогц арга хэмжээг зохион байгуулахад оролцох |
| | | | *Ойлголт, асуудлыг нээн илрүүлэх* | Сонирхож байгаагаа асуулт асууж илэрхийлэх | Эрж хайх, таньж мэдэх даалгаврыг хийхэд идэвхтэй оролцох | Өдөр тутмын амьдралд тулгарах асуудлыг нээн илрүүлэх, судлах | Асуудлыг олж харах, түүнийг нарийвчлан судалж шийдлийг хайх |
| | | | *Асуудлыг олон талаас авч үзэх, эргэцүүлэх* | Мэддэг мэргэжил/танил хүмүүсийн дүрд хувиран жүжиглэх | Тоглох, жүжиглэхдээ олон төрлийн дүрд хувирах | Өгүүлэл, мэдээлэл дэх өөр өөр дүрүүдийн байр суурийг авч үзэх | Өгүүлэл, жүжиг, үйл явдал өрнөх явцад дүрүүдийн үйл хөдлөл хэрхэн өөрчлөгдөж буйг хэлэлцэх |
| | | | *Холбоо хамаарлыг олох* | Үгийн баялаг, мэддэг зүйлсээ зургаар илэрхийлэх (жишээ нь: амьтан, байшин гэх мэт) | Шинэ сэдэв, агуулгыг өмнөх туршлагатайгаа холбож илэрхийлэх | Судалж шинжлэн таньж мэдэх даалгаврыг гүйцэтгэхэд идэвхтэй оролцох | Ухагдахуун хоорондын хамаарлыг оюуны зураглал зэрэг аргаар харуулах |
| | | *Санаа гаргах* | *Төрөл бүрийн санаа гаргах* | Асуудалд нэгээс олон шийдлийг гаргах | Дуу, шүлэг, бүтээлийн зарим хэсгийг өөчлөн өөр хувилбар гаргах | Хичээлийн сэдэв, үйл явдалд тохируулан төрөл бүрийн санаа, хувилбарыг гаргах | Шинэ санаа гаргахад идэвхтэй оролцох |
| | | | *Санаануудаа нэгтгэн сайжруулах* | Санаагаа илүү тодорхой болгох | Ямар нэг зүйлийг өөр зориулалтаар хэрэглэх боломжийг олж, тодорхой тайлбарлах | Бусдын санааг баяжуулах | Санааг хөгжүүлж, асуудлыг шийдвэрлэхэд мэдлэгээ хэрэглэх |
| | | | *Өөр хувилбар гаргах* | Шинэ, төсөөллийн дүрдээ өөрөө жүжиглэн тоглох | Шинэ, төсөөллийн дүрдээ орж жүжиглэх, тайлбарлах | “Хэрэв ... бол” асуултыг асууж, өөр хувилбар, боломжуудыг гаргах | Олон нийтээр хүлээн зөвшөөрсөн санаа, онолыг асууж судлан, түүний өвөрмөц хувилбарыг гаргах |
| | | *Санаагаа хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх* | *Санаануудаа турших сайжруулах* | Будах, зурах, зохион бүтээх зэрэг бүтээлч үйл хийхдээ санаагаа турших | Төрөл бүрийн хэрэгсэл, төхөөрөмжөөс хэрэглэн загвар, зохиомж бүтээх, тайлбарлах | Өөрийн шийдэл, загвар, зохиомжийг сайжруулах | Шинэ санаа, шийдэл, загвар, зохиомжийн үр нөлөөг туршин үнэлэх, сайжруулах |
| | | | *Санаа, шийдлээ тайлбарлах, танилцуулах, хэрэгжүүлэх* | Боломжоо ашиглан шинэ тоглоом, наадгай санаачлах | Өгүүллэг, бодлого зэргийг зохиох, санал дэвшүүлэх, тайлбарлах | Өөрийн санаа, шийдлийг итгэлтэйгээр танилцуулах | Судалгаа, төсөлт ажилдаа сонгосон аргын үндэслэлийг итгэлтэйгээр танилцуулах |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| Нээлттэй сэтгэгч | Шүүмжлэлт сэтгэхүй | Санаа, үндэслэлийг ойлгох, дүн шинжилгээ хийх | *Мэдээллийг тодорхойлох, ангилах* | Юмсыг хэлбэр, хэмжээ, өнгө, байршлаар нь ангилж, цэгцэлж, тодорхойлох | Сэдэв, агуулгад тохирох дүр, зохиомж, үндсэн санааг тодорхойлох | Үндэслэлийн үндсэн бүтцийг тодорхойлох | Үндэслэлийн гол санааг тодорхойлох |
| | | | *Юмсын онцлог шинж чанар, хоорондын хамаарлыг таних* | Юмс, хүн, үсэг, үгс гэх мэт зүйлсийг хооронд нь хамаатуулан холбох | Мэдээллийг төрөл, шинжээр нь харьцуулах (жишээ: ижил, ялгаатай шинж гэх мэт) | Өөр эх сурвалжууд дахь үндэслэл, гол санааг харьцуулах | Сэдэв, агуулга дахь ялгаатай байр суурь, үндэслэлийг харьцуулах |
| | | | *Өгөгдөл, үндэслэлээс гарсан таамаглал, дүгнэлтийг хэлэлцэх, дүрслэх* | Зураг, зохиомжоос хялбар таамаглал, дүгнэлтийг дүрслэн хэлэх | Тохиолдсон зүйлсийн шалтгааныг тайлбарлах | Үндэслэлийн гаргалгаа, таамаглал, дүгнэлтийг тодорхойлох | Үндэслэлд дурдаагүй таамаглал, алдаатай зүйлсийг олж илрүүлэх |
| | | Санаа, үндэслэлийг үнэлж дүгнэх | *Үндэслэлийн гол санааг үнэлж дүгнэх* | Ямар нэгэн зүйлийн үнэн, худлыг шүүн тунгаах | Ямар нэгэн зүйлийн үнэн, худлыг шүүн тунгаах, шалтгааныг олох | Нотолгоо гаргах, найдвартай байдлыг тодорхойлох | Үндэслэлүүд тодорхой, шударга, уялдаа холбоотой эсэхийг тогтоох |
| | | | *Үндэслэлийг бүхэлд нь үнэлж дүгнэх* | Эх бичвэр, дүрслэл нь бодит, хийсвэр эсэхийг тодорхойлох | Зохиолын дүрийн хэлсэн үгэнд итгэж болох эсэхийг тайлбарлах | Үндэслэлийн итгэл үнэмшилтэй байдал, шалтгааныг тодорхойлох | Үндэслэлийн сул талыг тодорхойлох |
| | | | *Тохиромжтой дүгнэлтийг гаргах* | Хамгийн их санал нийлж байгаа санааг сонгох | Тодорхой асуудлын шалтгааныг таамаглан дэвшүүлэх | Олон эх сурвалжаас гол санааг ялган, шинэ тайлбар, үндэслэл гаргах | Санаа, үндэслэлд тохирох үнэлэлт дүгнэлт гаргах |
| | | Асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах | *Асуудлыг ойлгох, тодорхойлох* | Зохиомж дахь дүрүүдийн асуудлыг тодорхойлох | Тодорхой агуулга, өгсөн нөхцөл дэх асуудлыг тодорхойлох | Төлөвлөлтөд ямар асуудал байгааг олж тогтоох | Судалж байгаа агуулга, төслийн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлыг тодорхойлох |
| | | | *Хамааралтай мэдээллийг олж авах, цэгцлэн тодорхойлох* | Асуудлыг шийдвэрлэж болох хувилбарыг олох | Ахуй амьдралын асуудлын боломжит шийдлийг олж тодорхойлох | Мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч, сэдвийг олон талаас авч үзэх, хэлэлцэх | Өгөгдөл, мэдээллийг эмх цэгцтэй цуглуулж, найдвартай байдлыг хангах шинжилгээ, дүгнэлтийг хийх |
| | | | *Сонголт, саналуудыг үнэлж шийдвэр гаргах* | Сонголтуудын аль нь сайн, аль нь муу болохыг тайлбарлах | Сэдвийн хүрээнд гарсан санал, сонголтын үр дагаврыг хэлэлцэж тайлбарлах | Өгсөн асуудал, нөхцөлд тохирох шийдлийг олж тодорхойлон, үр дүнг шалгах | Боломжит шийдлүүдийг системтэйгээр үнэлж дүгнэх |
| | | | *Шийдвэр, дүгнэлтийг зөвтгөх* | Тухайн сонголтыг хийсэн шалтгаанаа тайлбарлах | Сонголтын аль нь илүү болохыг илэрхийлэх, зөвтгөн тайлбарлах | Шийдлийн аль нь илүү болохыг илэрхийлэх, зөвтгөн тайлбарлах | Хамгийн сайн тохирох үйл ажиллагааг сонгох, зөвтгөх |
| | | | *Хэрэгжүүлсэн шийдлийн үр нөлөөг үнэлж дүгнэх* | Тухайн шийдэл тохиромжтой эсэхийг тайлбарлах | Өгсөн мэдээлэлд тулгуурлан таамаглал, тооцоолол гаргах | Шийдлийн аль хэсгийн ажиллагаа сайн болохыг илэрхийлэх | Хэрэгжүүлсэн шийдлээс сайжруулах хэсгийг тодорхойлох |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| Байнгын суралцагч | Суралцахуйд суралцах | Суралцахуйн арга барил, ур чадварыг хөгжүүлэх | *Тодорхой чиглүүлэг, зааврын дагуу суралцах үйл ажиллагаанд оролцох* | Тодорхой заавар, тогтсон дэг журмыг дагаж мөрдөх | Даалгавар гүйцэтгэхдээ зааврыг зохих ёсоор дагаж мөрдөх | Даалгаврыг бие даан гүйцэтгэхдээ зааврыг зохих ёсоор дагаж мөрдөх | Судалгаа, төсөлт ажлыг төлөвлөх, амжилттай хэрэгжүүлэх |
| | | | *Мэдээлэл олж авах, хадгалах, дахин цуглуулах арга барилд суралцах, хэрэглэх* | Энгийн асуулт асууж мэдээлэл олж авах | Тодорхой зорилготойгоор сэдэв, үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл хайх | Сэдэв, даалгаврын хүрээнд эмх цэгцтэй тэмдэглэл хийх | Хичээлээр судалсан, уншсан зүйлсийг эмх цэгцтэй тэмдэглэн бичих |
| | | | *Суралцах, мэдээллийг өөртөө шингээх үр дүнтэй аргыг хэрэглэх* | Цээжлэх, тогтоох аргад суралцах | Тодорхой сэдэв, агуулгатай холбоотой гол санаа, түлхүүр үгсийг тогтоон давтах | Нэр томьёог тохиромжтой аргаар тэмдэглэн авах | Мэдээлэл олж авах, суралцах боломжит нөөц, эх сурвалжийг үр дүнтэй хэрэглэх |
| | | | *Ойлголт, бүтээмжээ нэмэгдүүлэх үр дүнтэй аргыг хэрэглэх* | Тодорхой мэдээлэл, өгүүллийг ойлгоход зураг, дүрсийг хэрэглэх | Эх бичвэрийн зураг, гарчиг, дэд гарчгаас ерөнхий санааг олж харах | Хам сэдвээс танил бус үгсийн утгыг таамаглах | Тусгайгаас ерөнхий рүү, ерөнхийгөөс тусгай руу шилжих аргуудыг хэрэглэх |
| | | Суралцахуйн үйлээ хянах, удирдах | *Суралцах үйл ажиллагаанд зорилго тавьж, төлөвлөх* | Тодорхой сонголтуудаас алийг хийж дуусгахаа сонгох | Тодорхой даалгаврыг гүйцэтгэхдээ суралцах зорилтоо тодорхойлох | Үндсэн мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд анхаарч суралцах төлөвлөгөөгөө сайжруулах | Зорилгодоо хүрэхийн тулд суралцах үйл ажиллагаагаа төлөвлөх |
| | | | *Суралцах үйл ажиллагаагаа сайжруулах санаачилга гаргах* | Багшаас тусламж хүсэх | Хамтран суралцагчдаасаа тусламж, дэмжлэг хүсэх | Хичээлээс гадуур мэдлэг, чадвараа сайжруулах арга замаа сонгох | Суралцах чадвараа сайжруулахад тохиромжтой сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгох |
| | | | *Суралцах орчноо зохион байгуулах* | Сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрэгцээтэй үед хялбар олж болохоор эмхэлж цэгцлэх | Бусадтай үр бүтээлтэй, сатаарахгүйгээр хамтран ажиллах | Суралцах үйл ажиллагааг сатааруулах зүйлсийг багасгах | Үр дүнтэй суралцах боломжтой орчныг бүрдүүлэх |
| | | | *Сэтгэл хөдлөл, хандлагаа удирдах* | Сэтгэл хөдлөлөө хянахыг хичээх | Сэтгэл хөдлөлөө зохицуулах | Суралцахад сөргөөр нөлөөлж болзошгүй сэтгэл хөдлөлийн илрэлийг хянах, даван туулах | Сэтгэл хөдлөлөө удирдах |
| | | Суралцахуйн үйлээ эргэцүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх | *Суралцах ахицаа хянах* | Гүйцэтгэсэн даалгавраа тэмдэглэх энгийн хянах хуудас хэрэглэх | Суралцах үйл явц, ахицаа мэдэх, тэмдэглэх | Үнэлгээний шалгуур хэрэглэн ахиц дэвшлээ хянаж тэмдэглэх хуудас зохиох | Ахиц дэвшлээ тэмдэглэн, суралцах үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх, шинэ зорилго дэвшүүлэх |
| | | | *Суралцах үйл ажиллагаа, ахицаа үнэлэх* | Хүсэж байгаа ахиц, үр дүндээ хүрэхгүй байгаа санагдвал сурах аргаа өөрчлөх | Хичээл дээр юуг сайн, юуг тааруу хийснээ эргэцүүлэх | Юуг илүү сайн хийж болох талаар эргэцүүлж, мэдлэг, чадвараа хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах | Үнэлгээний тодорхой, тогтсон шалгуурыг хэрэглэн гүйцэтгэлээ үнэлж дүгнэх |
| | | | *Бусдын санал, бодол, шүүмжид үндэслэн суралцах үйл ажиллагаагаа сайжруулах* | Багш, эцэг эхийн хэлсэн санал, зөвлөгөө, шүүмжийг тусган авах, мөрдөх | Санал, шүүмжийг сонсож, эерэгээр хүлээн авах, яагаад тухайн санал шүүмж өгснийг ойлгох | Багш, үе тэнгийнхнийхээ санал зөвлөмжийг хүлээн авч, суралцах үйл ажиллагаагаа сайжруулахад хэрэглэх | Тохиромжтой үед үе тэнгийнхэн, багш нараас суралцах чадварынхаа талаар санал, зөвлөгөө өгөхийг хүсэх |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| Байнгын суралцагч | Дижитал ур чадвар | Цахимаар мэдээлэл солилцох, харилцах | *Тохирох технологийг хэрэглэн бусадтай холбогдох, харилцах* | Насанд хүрэгчийн заавар, дэмжлэгтэйгээр багш, үе тэнгийнхэн, гэр бүлийн гишүүдтэй цахимаар харилцах үндсэн үйлдлийг мэдэх, хэрэглэх | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр холбогдох эх сурвалж, дижитал контентийг багш, үе тэнгийнхэнтэйгээ солилцох | Багш, үе тэнгийнхэнтэйгээ харилцахад тохиромжтой дижитал хэрэгслүүдийг сонгон хэрэглэх | Тодорхой зорилгойгоор төрөл бүрийн нөхцөлд дижитал хэрэгслээр бусадтай холбогдохын давуу, сул талыг шүүн тунгаан үнэлж дүгнэх |
| | | | *Бусадтай цахимаар хамтран ажиллаж даалгаврыг гүйцэтгэх* | Дижитал төхөөрөмж дэх аппликэйшнийг хэрэглэн хамтдаа үйл хийх | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр нэгэн ижил хугацаанд холбогдон дижитал даалгаврыг хамтран гүйцэтгэх | Даалгаврыг хамтран гүйцэтгэхдээ хэрэглэх дижитал хэрэгслийн давуу, сул талыг хэлэлцэх | Цахим орчинд төрөл бүрийн нөхцөлд хамтран ажиллах хамгийн оновчтой аргыг сонгох |
| | | | *Цахим орчинд зохистой харилцах* | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр цахим харилцааны албан бус тэмдэгт, дүрсийг таних (жишээ нь: эмоц) | Цахим орчинд бусадтай хүндэтгэлтэй, эелдэг үг хэллэг хэрэглэн харилцах | Цахимаар саналаа солилцох, хариу өгөхдөө товч, тодорхой, хүндэтгэлийн үг хэллэг хэрэглэх | Нийгэм, соёлын хувьд ялгаатай хүмүүстэй харилцахдаа тохирох хэлбэр, арга стратегийг хэрэглэх |
| | | Дижитал хэрэгсэл ашиглах, контент бүтээх | *Хайлт хийх аргаа хөгжүүлэх, дижитал өгөгдөл, мэдээлэл, контентийг үр дүнтэй хэрэглэх* | Танил цахим хуудас, аппликэйшний таних тэмдгийг ялгах | Түлхүүр үг хэрэглэн үр дүнтэй хайлт хийх | Хайж олсон мэдээллийн эх сурвалжийг тэмдэглэн авч, ашигласан эх сурвалжийг дурдахад хэрэглэх | Хамгийн тохиромжтой контентийг олохын тулд хайлтын стандарт хэрэгслүүд, мэдээллийн сан, дэвшилтэт арга техникийг хэрэглэх |
| | | | *Дижитал өгөгдөл, мэдээлэл, контентийг шүүн тунгааж, санал шүүмжээ зүй зохистой илэрхийлэх* | Хялбар, танил сэдвийн хүрээнд насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр цахим орчин дахь мэдээллийн үнэн, худлыг ялгах | Хялбар шалгуурын дагуу цахим өгөгдөл, мэдээлэл, контентийг үнэлж дүгнэх | Үнэн, худал мэдээллийг ялгахын тулд үр дүнтэй арга стратегийг хэрэглэх | Даалгавар гүйцэтгэх, судалгаа хийхийн тулд цахим орчноос олсон мэдээллийн тохиромжтой, найдвартай байдлыг үнэлж дүгнэх |
| | | | *Тодорхой үр дүнд хүрэхийн тулд тохирох дижитал хэрэгслийг сонгох, хэрэглэх* | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр дижитал хэрэгслийг сонгох, ажиллуулах үйлдлийг мэдэж авах, хэрэглэх | Дижитал контентийг үзэх, бүтээхэд тохирох дижитал хэрэгслийг сонгон хэрэглэх | Хувийн зохион байгуулалтаа сайжруулахад дижитал хэрэгсэл дэх үйлдлийг хэрэглэх, жишээ нь: төлөвлөлт хийх, эсхүл тэмдэглэл хөтлөх гэх мэт | Интерактив суралцахуйд тохирох цахим хуудас, программ хангамжийг сонгон хэрэглэх |
| | | | *Дижитал контент бүтээж асуудал шийдвэрлэх, даалгаврыг гүйцэтгэх* | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр зураг авах, аудио, видео бичлэг хийх | Дижитал хэрэгслийг ашиглан төрөл бүрийн зохиомж хийж турших | Мэдээллийг цахим орчинд дүрслэхэд тохиромжтой форматыг сонгож хэрэглэх | Тодорхой зорилго, эсвэл оролцогчдод тохирох контент бүтээхийн тулд хэд хэдэн цахим форматыг сонгох, хэрэглэх |
| | | Цахим орчин дахь аюулгүй байдал | *Цахим орчинд аюулгүй байх* | Таагүй мэдрэмж төрүүлэх аливаа дижитал контент, эсвэл үйл ажиллагаанаас гарах, насанд хүрэгчдэд мэдэгдэх | Цахим халдлагын төрөл бүрийн хэлбэрийг таних (жишээ нь: гадуурхалт, дээрэлхэлт), тодорхой дэмжлэгтэйгээр зохицуулах арга замыг санал болгох (жишээ нь: screenshot, block хийх, мэдээлэх) | Цахим орчинд аюулгүй байдлыг хангахад дэмжлэг болох үйлдлийг тодорхойлон хэлэх (жишээ нь: хувийн тохиргоог зохих байдлаар хийх, блоклох / контентын талаар мэдээлэл өгөх) | Цахим халдлага, дарамт, зөвшөөрөлгүйгээр бусдын контентийг нийтлэх зэрэг цахим зан үйлтэй холбоотой хуулийн заалтыг мэдэх, хэрэглэх |
| | | | *Бие болон сэтгэл зүйн аюулгүй, тайван, эрсдэлгүй орчин бүрдүүлэх* | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, оролцогчдын талаар хялбар үг хэллэг хэрэглэн дүрслэх. | Технологийн хэрэглээний бие, сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тайлбарлах | Хэвлэл мэдээлэл, нийгмийн зүгээс хувь хүний сэтгэл зүйн тайван байдалд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг хэлэлцэх, сэргийлэх.. | Технологийн хэрэглээнээс үүдэлтэй бие, сэтгэл зүйн ноцтой асуудлыг дүрслэн илэрхийлж, уг асуудлаас сэргийлэх, бууруулах арга замыг хэлэлцэх |
| | | | *Дижитал систем, төхөөрөмжөө хамгаалах* | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр дижитал төхөөрөмжийг гамтай хэрэглэх | Насанд хүрэгчийн дэмжлэгтэйгээр хувийн мэдээллийг хамгаалах баталгаатай, тогтоож болох нууц үг хэрэглэх | Өгөгдлийн нөөц хувилбарыг хадгалах тохирох аргыг мэдэх, хэрэглэх | Хувийн мэдээлэл, цахим хаяг алдагдвал холбогдох газарт нь мэдэгдэж сэрэмжлүүлдэг байх |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| *Идэвхтэй хамтрагч* | *Харилцах* | *Тохиромжтой хэл хэрэглэх, нөхцөл байдлыг харгалзан харилцах* | *Тухайн нөхцөл байдалд тохирох хэлийг хэрэглэх* | Энгийн, эелдэг хэлбэрээр мэндлэх, танилцуулга хийх | Урилга, санал, уучлалт гуйх зэрэгт зохих ёсоор хариулах | Үг хэлэх, мэндлэх, үдэн гаргах тохиромжтой хэлбэрийг хэрэглэх | Үзэл бодлоо зөв илэрхийлэх |
| | | | *Хүссэн үр дүнд хүрэхийн тулд төрөл бүрийн хэл яриа, харилцах стратеги хэрэглэх* | Дүрд хувиран тоглож төрөл бүрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэхдээ дуу хоолойны өнгө, чанга, сулыг тохируулан өөрчлөх | Жүжиг, дүрд тоглох үед янз бүрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх аялгуу, дохио зангаа хэрэглэх | Тодорхой зүйлийг онцлоход тохирох хэл ашиглах (жишээ нь: хэтрүүлэг гэх мэт). | Бусдын анхаарлыг татахын тулд ярианы олон төрлийн хэлбэрийг ашиглах (жишээлбэл: асуулт, тушаал гэх мэт) |
| | | | *Хэлний хэрэглээг өөр өөр соёл, нийгмийн бүлэгт тохируулан өөрчлөх* | Төрөл бүрийн дүрд тохирох хэлээр харилцан тоглох | Хэл яриаг нийгмийн бүлэгт тохируулан харилцах | Янз бүрийн нөхцөлд харилцан ярилцахад ямар сэдвүүд тохиромжтой болохыг ойлгох | Харилцаж буй хүндээ тохируулж албан, хагас албан ёсны, эсвэл албан бус илэрхийллийг хэрэглэх |
| | | *Харилцах үйлийг хөнгөвчлөх* | *Харилцан яриаг хөнгөвчлөх арга стратеги хэрэглэх* | Ээлжлэн ярих | Бусдын яриаг эелдэгээр таслах | Яриа эхлүүлэх энгийн арга техникийг хэрэглэх | Ярианы сэдвийг зохих байдлаар өөрчлөх |
| | | | *Хэлний хомсдол, харилцах явц дахь зогсолт тасалдлыг даван туулах аргыг хэрэглэх* | Дахин давтахыг хүсэх гэх мэт харилцах үндсэн аргыг хэрэглэх | Ойлгомжгүй байвал өөр үг, хэллэг хэрэглэхийг хичээх | Өмнөх мэдлэгт тулгуурлан танил бус үг хэллэгийн утгыг таамаглах, эргэцүүлэх | Ярилцлага, хэлэлцүүлэгт үл ойлголцол гарсан тохиолдолд хөндлөнгөөс оролцох |
| | | *Тохиромжтой, итгэлтэй, ойлгомжтой харилцах* | *Яриа, бичвэрийг үр дүнтэй зохион байгуулах* | Энгийн холбоос хэрэглэн бүлэг үгсийг холбох | Хэл ярианд холбоос үгсийг хэрэглэх | Логик дараалалтай, тодорхой тайлбар, өгүүлэмжийг боловсруулж бэлтгэх | Тодорхой сэдвийн хүрээнд яриа, бичвэрийг логик дараалалтай байхаар зохион байгуулах |
| | | | *Тохиромжтой хэл, илтгэлийн хэв маягийг өөртөө итгэлтэй, чөлөөтэй хэрэглэх* | Энгийн асуултуудыг өөртөө итгэлтэйгээр асууж, хариулах | Өгүүлэл, үйл явдал болон ямар нэг зүйлийг тодорхой дүрслэх | Аман харилцааг дэмжих нүүрний хувирал, нүдний харцыг зөв ашиглах | Илтгэл тавихдаа тогтмол хэмнэлээр ярих |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| *Идэвхтэй хамтрагч* | *Хамтран ажиллах* | *Багийн ажилд хувь нэмэр оруулахдаа хувийн хариуцлага хүлээх* | *Аливаа ажилд идэвхтэй хувь нэмэр оруулах* | Зураг, өгүүлэл, туршлага сургамжийн талаар санаа бодлоо хуваалцах | Даалгаврыг гүйцэтгэхдээ танил болон танил бус сэдвүүдийн талаар саналаа хуваалцах | Одоогийн ярианы сэдэвт үндэслэн холбогдох саналуудыг гаргах | Хэлэлцүүлэг, багийн даалгаврын туршид холбогдох санааг санал болгох |
| | | | *Янз бүрийн дүрд тоглох* | Үйл ажиллагаанд дүрүүдийн оруулах хувь нэмрийг тодорхойлох | Даалгаврын зорилгыг биелүүлэхэд дэд даалгавруудын оруулах хувь нэмрийг тодорхойлох | Тодорхой үүргийг сайн дураар өөртөө авах | Өөр өөр тохиолдолд өөр өөр дүрд тоглох, эсвэл үүрэг хүлээх уян хатан байдлыг харуулах |
| | | *Багийн үр дүнтэй харилцааг дэмжих* | *Сонсож, хүндэтгэлтэйгээр хариулах* | Бусдын санаанд тулгуурлан харилцах | Тохиромжтой мөчид багийн яриаг эелдэгээр таслах | Өөрийн үг хэлэх ээлжийг хүндэтгэлтэйгээр хүлээх | Янз бүрийн санаа, тэр дундаа эсрэг талын үзэл бодлыг илэрхийлсэн санаануудад нээлттэй байдлаар хариулах |
| | | | *Хамтран ажиллах арга замыг бий болгох* | Тоглоомын дүрмийг тогтоох | Багийн дүрмийг зохиоход хувь нэмэр оруулах | Багийн гишүүн бүр даалгавраа ямар хугацаанд хийхийг тогтоох | Даалгаврыг хамтран гүйцэтгэх шилдэг аргуудын талаар ярилцах |
| | | | *Бусдын оролцоог хангах, дэмжих* | Хүн бүр санал бодлоо хуваалцахыг хүсэж, санал нэгдэж байгаа эсэхийг шалгах | Баг доторх ичимхий, өөртөө итгэлгүй байж болох гишүүдийг зоригжуулан дэмжих | Бусад суралцагчдад санаагаа илэрхийлэхэд нь туслах | Хэлэлцүүлгийн явцад бусдыг санаа, бодлоо илэрхийлэхийг хүсэх |
| | | *Багийн үйл ажиллагаанд даалгавруудыг хуваарилан удирдах* | *Хийх ёстой зүйлээ хүлээн зөвшөөрөх* | Үйл ажиллагааг дуусгахад шаардлагатай алхмуудыг тайлбарлах | Тохиромжтой үед үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлэх талаар бусдын санаа бодлыг нэгтгэх | Даалгаврын талаар бусад суралцагчдаас асууж тодруулан, шаардлагатай үед даалгаврын шаардлагыг тодорхой тайлбарлах | Даалгаврыг дуусгахад шаардлагатай алхмуудыг тодорхойлох |
| | | | *Ажлын хуваарилалтыг гарган удирдах* | Багийн гишүүдэд гүйцэтгэх үүргийг санал болгох | Багийн гишүүдэд гүйцэтгэх үүргийг хуваарилах | Бусад суралцагчдад эелдэг, хүндэтгэлтэй хандах | Даалгавруудыг шударга, зохистой хуваарилахад хувь нэмэр оруулах (жишээлбэл: багийн гишүүдийн ур чадварыг харгалзах). |
| | | *Даалгавраа дуусгахын төлөө ажиллах* | *Зорилгодоо хүрэх ахиц дэвшлийг баталгаажуулах* | Багийн гишүүдийн анхаарлыг сарниулахгүй байх | Багийн анхаарлыг сарниулж болзошгүй саад бэрхшээлийг үл харгалзан зорилгодоо төвлөрөх | Бусад суралцагчдыг үйл ажиллагаандаа анхаарлаа хандуулахыг хэлж урамшуулах | Багийн анхаарлыг сарниулах саад бэрхшээлийг үл харгалзан зорилгод нь төвлөрүүлэх |
| | | | *Асуудал, бэрхшээлийг тодорхойлох* | Өөрийн, эсвэл өөр хүүхдийн зан байдлаас үүсэж болох асуудлыг таних | Багийн гишүүдийн хооронд асуудал гарсан тохиолдолд хүлээн зөвшөөрөх | Санал нийлэхгүй байгаа шалтгааныг тодорхойлох | Өөрийн, эсвэл өөр хүүхдийн зан байдлаас асуудал үүсэж байгааг хүлээн зөвшөөрөх |
| | | | *Асуудлыг шийдвэрлэх* | Багт үүссэн асуудлыг шийдвэрлэхийг хичээх | Багийн даалгаврыг биелүүлэхийн тулд асуудлыг хэрхэн шийдвэрлэхээ шийдэх | Багт үүссэн асуудлыг хэлэлцэж, шийдлийн талаар санал нэгдэхийг бусдад санал болгох | Хамтран ажиллахад гарах асуудлыг тохиромжтой байдлаар шийдвэрлэх |

| | *Чадамж* | *Үндсэн хүрээ* | *Бүрэлдэхүүн* | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| *Хүнлэг иргэн* | *Хариуцлагатай байх* | *Нийгмийн бүлгийн нөлөөлөл болохын хувьд хувь хүний хариуцлагаа ойлгох* | *Нийгмийн бүлэг доторх үүрэг хариуцлагаа ойлгох* | Бага насны хүүхдийн үндсэн үүрэг, хариуцлагыг мэдэх, тайлбарлах | Нийгмийн ялгаатай бүлэг дэх үүрэг, хариуцлагаа тодорхойлох | Харьяалагддаг нийгмийн бүлгүүдийн зөрөг зан үйлийг тодорхойлох | Нийгмийн янз бүрийн бүлгийн гишүүдийн үүрэг, хариуцлагын талаар шүүн тунгааж, дүн шинжилгээ хийх |
| | | | *Нийгмийн бүлэг доторх үүрэг хариуцлагаа биелүүлэх* | Өөрчлөх шаардлагатай зан үйлээ таньж, засаж залруулах | Сургуулийн дүрэм журмыг дагаж мөрдөх, зөрөг зан үйлийг сонгон хийх | Сургуулийн хамтын эрх, үүргийг тодорхойлоход идэвхтэй оролцох | Ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтийг таньж мэдэх, зохистой арга хэмжээг авах |
| | | *Соёл хоорондын ойлголтоо илэрхийлэх* | *Өөрсдийн соёлыг мэдэж ойлгох* | Орчныхоо танил газар, дурсгалт газруудыг мэдэх | Үндэсний соёл уламжлалын талаар мэдэх, тайлбарлах | Өөрсдийн соёл, үнэ цэнийг үнэлэх | Соёлынхоо нийтлэг үнэт зүйлс, итгэл үнэмшил зэрэгт дүн шинжилгээ хийх |
| | | | *Бусдын соёлыг мэдэж ойлгох* | Улс орнуудын хоол хүнс, баяр наадам, хөгжмөөс мэддэгээ хэлэх | Өөрийн болон бусад улс орны ижил төстэй, ялгаатай талуудыг олж тогтоох | Өөрийн болон бусад нийгэм, соёлыг харьцуулах | Нийгэм, соёл хооронд харьцуулалт, ялгаатай байдлыг үнэлэх, хүндэтгэлтэй хандах |
| | | | *Бусад соёл иргэншилтэй хүмүүстэй харилцах* | Бусад хүүхдүүдээс санал бодлыг нь асуух | Өөрсдийн болон бусад соёлын хүмүүсийн харилцааны ижил төстэй болон ялгаатай талуудыг тодорхойлох | Буруу ойлголтоос зайлсхийхийн тулд соёлын ялгааны талаарх мэдлэг, ойлголтоо хэрэглэх | Хүмүүстэй үр дүнтэй харилцахын тулд тэдний соёл, үнэт зүйлсийн ялгааны талаарх мэдлэгээ хэрэглэх |
| | | *Дэлхийн хэмжээний асуудлыг ойлгох* | *Дэлхийн олон талын асуудлыг хэлэлцэх* | Хүний амьдралын үндсэн хэрэгцээг (жишээ нь: орон байр, хоол хүнс, ус гэх мэт) тодорхойлох | Нийтлэг өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх ач холбогдлыг тайлбарлах (жишээлбэл: эрүүл ахуйн арга хэмжээ авах) | Хүний эрхийн талаарх дэлхийн түвшний асуудалд анхаарал хандуулах | Дэлхий нийтийн асуудал, боломжит шийдлүүдийг шүүн тунгаах, дүн шинжилгээ хийх |
| | | | *Дэлхийн хэмжээний асуудалд үзүүлэх хувь хүний нөлөөллийг таньж мэдэх* | Байгаль орчныг хамгаалах арга замуудыг тайлбарлах (жишээлбэл: ус хэмнэх, дахин боловсруулах гэх мэт) | Нөөцийг хуваалцах, хамгаалах хэрэгцээг ойлгох | Хувийн дадал зуршил, зан үйл нь хүрээлэн буй орчинд нөлөөлж буй эсэхийг тодорхойлох, зохих арга хэмжээг авах | Өөрийн болон байгууллагынхаа зан үйлийг байгаль орчинд ээлтэй эсэхийг үнэлж дүгнэх, зөрөг зан үйлийг эрхэмлэн хэрэгжүүлэх |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| Хүнлэг иргэн | Сэтгэл хөдлөлийн хөгжил | Сэтгэл хөдлөлийг таньж, ойлгох | Сэтгэл хөдлөлийг таньж, дүрслэх | Сэтгэл хөдлөлийн үндсэн төлөвийг тодорхойлох (жишээ нь: аз жаргалтай, гунигтай, догдолсон, уйтгартай, уууртай, айсан эсвэл гомдсон) | Янз бүрийн сэтгэл хөдлөлийг дүрслэх | Төрөл бүрийн сэтгэл хөдлөлийг өргөн хүрээг дүрслэх | Ялгаатай болон ижил төстэй сэтгэл хөдлөлийг (жишээ нь: аз жаргал, баяр баясгалан)-г таних, ялгах |
| | | | Сэтгэл хөдлөлийг ойлгох | Сайхан мэдрэмж төрүүлдэг, эсвэл гунигтай болгодог зүйлсийг нэрлэх | Тэднийг юу аз жаргалтай, гунигтай эсвэл бухимдаж байгааг дүрслэх | Өөр өөр сэтгэл хөдлөлийг юу юу төрүүлдэг талаар ярилцах | Стресс эсвэл хүнд хэцүү нөхцөл байдлыг бий болгодог зүйлсийг тодорхой илэрхийлэх |
| | | Өөрийнхөө сэтгэл хөдлөлийг удирдах | Өөрийн сэтгэл хөдлөлийг үнэлж хянаж, шинжих | Мэдэрч байгаа сэтгэл хөдлөлөө үгээр илэрхийлэх | Өөртөө болон/эсвэл бусадтай сэтгэл хөдлөлийх нь талаар ярилцах | Сэтгэл хөдлөлийн талаар ярилцаж, эргэцүүлэх (голчлон найзуудтайгаа). | Сэтгэл хөдлөл, сэтгэл хөдлөлийн менежментийн талаарх өөрийн туршлагаа тусгах (жишээ нь: сэтгэл хөдлөлийн өдрийн тэмдэглэл хөтлөх). |
| | | | Сэтгэл хөдлөлийг зохицуулах | Сэтгэл хөдлөлөө хянахыг оролдох. | Уурлаж бухимдах, стресст орсон үед сэтгэл хөдлөлөө хянах стратеги (жишээлбэл: амьсгалын техник) ашиглах | Нөхцөл байдлыг дахин үнэлэх, өөрчлөх зэрэг стратеги ашиглан сэтгэл хөдлөлөө удирдах | Стресс, бухимдал, уур хилэнг бий болгож буй асуудлуудыг шийдвэрлэх стратегийг ашиглах |
| | | | Эерэг харилцаа тогтоох, хадгалах | Найз нөхөрлөлийг бий болгож эхлэх | Найз нөхөдтэй болох, сайн найз болох арга замыг (жишээ нь: хуваалцах, сонсох, туслах, бусдын эд зүйлсийг хүндэтгэх гэх мэт) тодорхойлох | Эрүүл харилцааг хадгалахын төлөө ажиллах | Үе тэнгийнхэн, багш нартайгаа нийгмийн зохистой харилцааг хадгалах |
| | | Бусдыг ойлгох чанар болон харилцан хамааралтай байх | Бусдын мэдрэмжийг ойлгох, өрөвдөх сэтгэлийг харуулах | Бусдыг гомдоосон, шударга бус харилцааг ойлгож эхлэх (худлаа хэлэх, үл тоомсорлох, шоолох, цохих, гадуурхах гэх мэт) | Бусад хүүхдүүдийг гомдоох, бухимдах үед тэдэнд санаа тавьж, өрөвдөх | Бусад хүмүүсийн үзэл бодол, мэдрэмжийг ойлгодог болохоо харуулах | Санал зөрөлдөөн, маргаан үүсгэж болзошгүй зүйлийг мэдрэмжтэй, хүндэтгэлтэй илэрхийлэх |
| | | | Бусдыг дэмжих | Бусдыг тайвшруулах (жишээлбэл, тэднийг тэврэх эсвэл тоглоом санал болгох) | Шаардлагатай үед бусдад тусалж, тайвшруулах | Зөрчилдөөнийг бүтээлчээр хэлэлцэх | Тэмцэж буй бусад хүмүүст бодит дэмжлэг үзүүлэх |

| Чадамж | | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| Соёлын өв тээгч | Дэлхийн өв соёл | *Дэлхийн өв соёл, түүхийг сонирхох, таньж мэдэх* | *Дэлхийн хүн төрөлхтний түүх, соёл, аж амьдрал, зан заншлыг ойлгохыг эрмэлзэх*<br>*Дэлхийн түүхэн өв соёлын дурсгалт зүйлсийг хадгалах, хамгаалах талаар санал санаачилга гаргах* | Дэлхийн сонгодог үлгэр сонсож, сайн, муу үйлийг ялган таних<br>Олон хэл, соёл, зан заншил, уламжлалыг өвлөх, хамгаалах арга туршлагаас суралцах | Хүн төрөлхтний аж амьдрал, зан заншлын талаар өгүүлсэн уран бүтээлтэй танилцаж, өөрт төрсөн бодол сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх<br>Олон хэл, соёл, зан заншил, уламжлалыг өвлөх, хамгаалахад идэвхтэй оролцох | Хүн төрөлхтний өв соёл, түүхийн гол үйл явдал, түүхэн эх сурвалжийг судалж, онцлог, ач холбогдол, үр дагаврыг тайлбарлах<br>Дэлхийн өв соёл, түүхийн үнэт зүйлийг өвлөх, хамгаалах арга ухаанд суралцах | Дэлхийн түүхэн өв соёлыг судлах, санал бодлоо илэрхийлэх, дэвшүүлсэн асуудлын тухай “дэмжсэн” эсвэл “эсрэг” байр сууриа харуулах<br>Дэлхийн түүхэн өв соёлын дурсгалт зүйлсийг хадгалах, хамгаалах талаар өөрийн санал, санаачилга дэвшүүлэх |
| | | *Дэлхийн өв соёл, түүхийг хүндэтгэн дээдлэх* | *Улс, үндэстний соёлын үнэт зүйлд хүндэтгэлтэй хандах*<br>*Хүн төрөлхтний түүх, соёлын үнэт зүйл, хэл бичиг, урлагаар бахархах* | Гэр бүлийнхэн (эцэг эх, эмээ өвөө, ах, дүү)-ийхээ намтар, онцлогийг бахархан ярих<br>Өөрийн үндэсний өв соёл (хэл, ёс заншил, хувцас, хэрэглэл гэх мэт) нь бусад үндэстний өв соёлоос ялгаатайг бусдад танилцуулах | Улс, үндэстэн бүрийн соёлын үнэт зүйлд хүндэтгэлтэй хандаж байгаагаа бодит жишээгээр харуулах<br>Соёл, түүхийн олон талт байдлын адил болон ялгаатай талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх | Улс, үндэстэн бүрийн эх хэл, урлаг, соёлд хүндэтгэлтэй хандаж байгаагаа өөрийн авьяас, чадвараар илэрхийлэн харуулах<br>Улс, үндэстэн бүрийн түүхийн үнэт зүйлийг бусдад түгээх, таниулах арга замыг эрэлхийлж таниулах | Хүн төрөлхтний үнэт зүйл, хэл бичиг, урлаг, соёлоор бахархаж, түүнийг өөрийн авьяас, чадвар, бүтээлээр илэрхийлэх<br>Хүн төрөлхтний соёл, түүхийг цаг үетэйгээ харьцуулах, адил болон ялгаатай талыг янз бүрийн хэлбэрүүдийг ашиглан таниулах |
| | | *Дэлхийн өв соёл, түүхийг таниулах, хөгжүүлэх* | *Бусад улс орны түүх, соёл, үнэт зүйлийг таниулах*<br>*Дэлхийн олон соёл хоорондын харилцан хамаарлыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, энх тайван байдал, тогтвортой хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах* | Өөрийн үндэсний өв соёл (хэл, ёс заншил, хувцас, хэрэглэл гэх мэт) нь бусад үндэстнээс ялгаатай болохыг илэрхийлдэг<br>Дэлхийн улс орнуудын адил, ялгаатай талыг тайлбарлах | Соёл, түүхийн олон янз байдлын адил болон ялгаатай талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх<br>Бусад улс орны соёл түүхийн харилцан хамаарлыг ойлгох, энх тайвны эрхэмлэж сурах | Бусад улс орны түүх, соёл, үнэт зүйл, итгэл үнэмшлийг хамгаалах, хүндэтгэх, хөгжүүлэх арга замыг эрэлхийлэх<br>Байгаль дэлхийг хүндэтгэх, тогтвортой амьдралын хэв маягийг ойлгож, өөрийн хувь нэмрээ оруулахад суралцах | Хүн төрөлхтний соёл, түүхийг цаг үетэйгээ харьцуулах, адил болон ялгаатай талыг янз бүрийн хэлбэрүүдийг ашиглан таниулах,<br>Дэлхий ертөнцийн энх тайван байдал, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах үйл ажиллагаа санаачилах, оролцох |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сургуулийн өмнөх боловсрол | Бага боловсрол | Суурь боловсрол | Бүрэн дунд боловсрол |
| Соёлын өв тээгч | Үндэсний өв соёл | Үндэсний өв соёл, түүхийг сонирхох, таньж мэдэх | *Ахмад настан, анд найз, дүү нартайгаа хүндлэхийн ач тусыг ухамсарлах* | Аав ээж, ахмад настнаа (тоглоомоо хураах, заавар дагах, тоглоомын талбайд тоглох дүрмийг сахих гэх мэт) хүндэтгэхийг нь энгийн үг хэллэгээр тайлбарлаж ойлгуулах | Тодорхой бүлэг, хамтлагийн (анги, гэр бүл, найз нөхдийн гэх мэт) хүрээнд эерэг, хамтач үйлийг тодорхойлох | Тодорхой бүлэг, хамтлагийн (анги, гэр бүл, найз нөхдийн гэх мэт) хүрээнд хүндэтгэл, хүндлэлийн үйлийг тодорхойлох | Нийгмийн янз бүрийн бүлэг, хамтлагийн гишүүний хүндлэх, хүндэтгэх байдлыг шинжилж ойлгох |
| | | | *Ахмад настан, анд найз, дүү нартайгаа эе эеээ хичээх хүндэтгэлтэй хандах* | Ахмад настнаа хүндэтгэн харилцах арга ухаан, эе эвээ хичээхэд суралцах | Сургууль, сургуулийн орчинд мөрдөгдөх дүрэм, журмыг дагах, эерэг,бусдад хүндэтгэлтэй хандан биеэ авч явах | Сургууль, сургуулийн орчинд мөрдөгдөх эрх, үүргийг тодорхойлоход идэвхтэй оролцох | Бусдад хүндэтгэлгүй хандах зан авирыг илрүүлж няцаах, илүү сайхан харилцааг санал болгох, өөрийн биеэр харуулах |
| | | Үндэсний өв соёл, түүхийг хүндэтгэх, дээдлэн | *Нутаг орныхоо дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудаар бахархах* | Ойр орчныхоо (цэцэрлэг, тоглоомын талбай, гэр гэх мэт) хүн их цугладаг эсвэл дурсгалт газруудыг нэрлэж тодорхойлж ярьж чаддаг байх | Өөрийн орон нутгийнхаа (түүхийн дурсгалт газар, байгалийн цогцолбор газар гэх мэт) талаар товч мэдээлэл өгөх | Өөрийн нутаг орны соёл, газар нутгийн үнэ цэнийг эрхэмлэх | Өөрийн соёлын нийтлэг үнэ зүйл, итгэл үнэмшил газар нутаг зэрэг гол ойлголтуудыг таньж ойлгох |
| | | | *Монгол хэл, урлаг, соёл, түүх зан заншил, оюуны өвийг хадгалах, хамгаалах* | Бусад улс орны хэл, баяр наадам, байгаль орчинг харьцуулж ярих | Өөрийн болон бусад улс орны ард иргэдийн өв соёлын ижил болон ялгаатай талыг тодорхойлох | Өөрийн болон бусад бүлэг, нийтлэгийг бодит мэдээлэлд үндэслэн харьцуулж авч үзэх | Өөр өөр соёл, нийгмийн бүлэг, хамтлагийн ялгааг харьцуулж ойлгох, давуу талыг … хэлэх |
| | | Үндэсний өв соёл, түүхийг таниулах, хөгжүүлэх | *Үндэсний өв, соёл, түүхийн үнэт зүйлс, зан заншлаа хүндэтгэх, үе тэнгийхэндээ таниулах* | Өв соёл, үнэт зүйлс, заншлыг (амьдралын хэв маяг, адилсал, бахархал зүйл гэх мэт) тодорхойлох, таниулах | Монгол хүний соёлын үнэт зүйл, зан заншлын (замын хөдөлгөөнд оролцох, харилцахдаа гэх мэт) ач тусыг тайлбарлах | Үл ойлголцол үүсэхээс сэргийлэхийн тулд олон соёлын ялгааг ойлгох, мэдээллээ ашиглах | Өөр соёлын хүмүүстэй үр өгөөжтэй харилцахын тулд өөрийн үндэсний өв соёл, түүхийн тухай мэдээлэл цуглуулж ашиглах |
| | | | *Үндэсний язгуур урлагаа сэргээн хөгжүүлэх, үндэсний уламжлалт сэтгэлгээ, зан заншлаа хадгалах, өвлүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах* | Монголчуудын хүн хүнтэйгээ, хүн малтайгаа, хүн байгальтай (хүн хүндээ туслах, малаа арчилж тордох, булаг усаа хайрлах гэх мэт) нэрлэх | Байгалийн орчноо хайрлан хамгаалах шаардлагатайг ойлгож тайлбарлах | Хүний эрхийн асуудалд дэлхий дахинаа анхаарал хандуулж байгааг тайлбарлах | Өв соёл уламжлалаа хадгалах, өвлүүлэх талаар тэдгээрийн шийдлийг нь эргэцүүлж хэлэлцэх |

# ЧАДАМЖ (бага боловсрол)

| Чадамж | | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл |
|---|---|---|---|---|
| Нээлттэй сэтгэгч | Бүтээлч сэтгэхүй | Бүтээлч байдалд бэлдэх | Олон төрлийн бүтээлч үйл ажиллагаанд оролцох | Уран сэтгэмжээ илэрхийлэх үйл ажиллагаанд оролцох |
| | | | Ойлголт, асуудлыг нээн илрүүлэх | Эрж хайх, таньж мэдэх даалгаврыг хийхэд идэвхтэй оролцох |
| | | | Асуудлыг олон талаас авч үзэх, эргэцүүлэх | Тоглох, жүжиглэхдээ олон төрлийн дүрд хувирах |
| | | | Холбоо хамаарлыг олох | Шинэ сэдэв, агуулгыг өмнөх туршлагатайгаа холбож илэрхийлэх |
| | | Санаа гаргах | Төрөл бүрийн санаа гаргах | Дуу, шүлэг, бүтээлийн зарим хэсгийг өөчлөн өөр хувилбар гаргах |
| | | | Санаануудаа нэгтгэн сайжруулах | Ямар нэг зүйлийг өөр зориулалтаар хэрэглэх боломжийг олж, тодорхой тайлбарлах |
| | | | Өөр хувилбар гаргах | Шинэ, төсөөллийн дүрдээ орж жүжиглэх, тайлбарлах |
| | | Санаагаа хэрэгжүүлэх, асуудлыг шийдвэрлэх | Санаануудаа турших сайжруулах | Төрөл бүрийн хэрэгсэл, төхөөрөмж хэрэглэн загвар, зохиомж бүтээх, тайлбарлах |
| | | | Санаа, шийдлээ тайлбарлах, танилцуулах, хэрэгжүүлэх | Өгүүллэг, бодлого зэргийг зохиох, санал дэвшүүлэх, тайлбарлах |
| | Шүүмжлэлт сэтгэхүй | Санаа, үндэслэлийг ойлгох, дүн шинжилгээ хийх | Мэдээллийг тодорхойлох, ангилах | Сэдэв, агуулгад тохирох дүр, зохиомж, үндсэн санааг тодорхойлох |
| | | | Юмсын онцлог шинж чанар, хоорондын хамаарлыг таних | Мэдээллийг төрөл, шинжээр нь харьцуулах (жишээ: ижил, ялгаатай шинж гэх мэт) |
| | | | Өгөгдөл, үндэслэлээс гарсан таамаглал, дүгнэлтийг хэлэлцэх, дүрслэх | Тохиолдсон зүйлсийн шалтгааныг тайлбарлах |
| | | Санаа, үндэслэлийг үнэлж дүгнэх | Үндэслэлийн гол санааг үнэлж дүгнэх | Ямар нэгэн зүйлийн үнэн, худлыг шүүн тунгаах, шалтгааныг олох |
| | | | Үндэслэлийг бүхэлд нь үнэлж дүгнэх | Зохиолын дүрийн хэлсэн үгэнд итгэж болох эсэхийг тайлбарлах |
| | | | Тохиромжтой дүгнэлтийг гаргах | Тодорхой асуудлын шалтгааныг таамаглан дэвшүүлэх |
| | | Асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах | Асуудлыг ойлгох, тодорхойлох | Тодорхой агуулга, өгсөн нөхцөл дэх асуудлыг тодорхойлох |
| | | | Хамааралтай мэдээллийг олж авах, цэгцлэн тодорхойлох | Ахуй амьдралын асуудлын боломжит шийдлийг олж тодорхойлох |
| | | | Сонголт, саналуудыг үнэлж шийдвэр гаргах | Сэдвийн хүрээнд гарсан санал, сонголтын үр дагаврыг хэлэлцэж тайлбарлах |
| | | | Шийдвэр, дүгнэлтийг зөвтгөх | Сонголтын аль нь илүү болохыг илэрхийлэх, зөвтгөн тайлбарлах |
| | | | Хэрэгжүүлсэн шийдлийн үр нөлөөг үнэлж дүгнэх | Өгсөн мэдээлэлд тулгуурлан таамаглал, тооцоолол гаргах |
| Байнгын суралцагч | Суралцахуйд суралцах | Суралцахуйн арга барил, ур чадварыг хөгжүүлэх | Тодорхой чиглүүлэг, зааврын дагуу суралцах үйл ажиллагаанд оролцох | Даалгавар гүйцэтгэхдээ зааврыг зохих ёсоор дагаж мөрдөх |
| | | | Мэдээлэл олж авах, хадгалах, дахин цуглуулах арга барилд суралцах, хэрэглэх | Тодорхой зорилготойгоор сэдэв, үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл хайх |
| | | | Суралцах, мэдээллийг өөртөө шингээх үр дүнтэй аргыг хэрэглэх | Тодорхой сэдэв, агуулгатай холбоотой гол санаа, түлхүүр үгсийг тогтоон давтах |
| | | | Ойлголт, бүтээмжээ нэмэгдүүлэх үр дүнтэй аргыг хэрэглэх | Эх бичвэрийн зураг, гарчиг, дэд гарчгаас ерөнхий санааг олж харах |
| | | Суралцахуйн үйлээ хянах, удирдах | Суралцах үйл ажиллагаанд зорилго тавьж, төлөвлөх | Тодорхой даалгаврыг гүйцэтгэхдээ суралцах зорилтоо тодорхойлох |
| | | | Суралцах үйл ажиллагаагаа сайжруулах санаачилга гаргах | Хамтран суралцагчдаасаа тусламж, дэмжлэг хүсэх |
| | | | Суралцах орчноо зохион байгуулах | Бусадтай үр бүтээлтэй, сатаарахгүйгээр хамтран ажиллах |
| | | | Сэтгэл хөдлөл, хандлагаа удирдах | Сэтгэл хөдлөлөө зохицуулах |
| | | Суралцахуйн үйлээ эргэцүүлэх, үнэлэлт, дүгнэлт өгөх | Суралцах ахицаа хянах | Суралцах үйл явц, ахицаа мэдэх, тэмдэглэх |
| | | | Суралцах үйл ажиллагаа, ахицаа үнэлэх | Хичээл дээр юуг сайн, юуг тааруу хийснээ эргэцүүлэх |
| | | | Бусдын санал, бодол, шүүмжид үндэслэн суралцах үйл ажиллагаагаа сайжруулах | Санал, шүүмжийг сонсож, эерэгээр хүлээн авах, яагаад тухайн санал шүүмж өгснийг ойлгох |

| | Чадамж | Үндсэн хүрээ | Бүрэлдэхүүн | Жишиг үйл |
|---|---|---|---|---|
| 5 | Урлаг, Технологи, ICT | Хөгжим (1-5)<br>Дүрслэх урлаг, технологи (1-5)<br><br>ICT (2 хувилбар) | 1-2 дугаар ангид Технологи+ICT интеграц хөтөлбөр<br>3-5 дугаар ангид ICT хичээл болох<br><br>1-5 дугаар ангид ICT тусдаа хичээл болох | 13 хувь | 13 хувь |
| 6 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир, эрүүл мэнд (1-5) | Биеийн тамир+Эрүүл мэндийн интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 10 хувь | 9 хувь |
| Цагийн зохицуулалтыг сургууль өөрөө хийх боломжтой, Үндэсний сургалтын хөтөлбөрт нийцсэн Орон нутаг санал болгосон Сургуулиас сонгосон заавал судлах хичээл байх | | | Сургууль нь орон нутаг, сурагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн бүтээлч, практик үйл ажиллагаагаар дамжуулан анги бүрд өөр зорилго чиглэлтэйгээр танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулах | 5 хувь | 10 хувь |

- 3-5 дугаар ангид Англи хэл заах багш... (Англи хэл заадаг бага ангийн багш бэлтгэх, эсвэл Англи хэлний багшид бага ангид заах эрх олгох тухай)
- ICT-ийг бага ангид заах багш...
- Хөтөлбөр боловсруулагчийн ойлголт, чадавх (интеграц хөтөлбөр...)
- Бага ангид ICT орох орчин, нөхцөл бүрдүүлэх
- Багш бэлтгэх, сургах (интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх)
- Биеийн тамир ба эрүүл мэндийг интеграц агуулгаар судлах



## *Хувилбарт хамаарах хичээл, эзлэх хувь (Суурь боловсрол)*

| № | Суралцахуйн хүрээ | Хичээл | Тайлбар | Суурь боловсрол | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Монгол | OECD |
| 1 | Хэл, харилцаа | Монгол хэл (6-9)<br>Уран зохиол (6-9)<br>Үндэсний бичиг (6-9)<br>Анхдагч гадаад хэл (6-9)<br>Сонгон судлах гадаад хэл (8-9) | Сонгон судлах гадаад хэлийг сурагчийн хэрэгцээ сонирхол, багшийн нөөцөд тулгуурлан 8 дугаар ангиас үзнэ. | 31 хувь | 29 хувь |
| 2 | Математик | Математик (6-9) | Математикийн хөтөлбөрт ICT-ийн хэрэглээг тусгах | 12 хувь | 12 хувь |
| 3 | Байгалийн ухаан | Биологи (6-9)<br>Физик (6-9)<br>Хими (7,8-9) | Байгалийн ухааны хөтөлбөрт ICT-ийн хэрэглээг дэмжих, технологийн дэвшлийг ашиглан туршилт, сорил хийх | 15 хувь | 12 хувь |
| 4 | Нийгмийн ухаан | Түүх (6-9)<br>Ёс зүйн боловсрол+Нийгэм судлал (8-9)<br>Газарзүй (6-8) | 6-9 дүгээр ангид Ёс зүйн+Нийгэм судлалын интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 15 хувь | 14 хувь |
| 5 | Урлаг, технологи, ICT | Дүрслэх урлаг (6-8)<br>Хөгжим (6-9)<br>Дизайн технологи (зураг зүй, технологи) (6-9)<br>Мэдээллийн технологи (6-9) | Зураг зүй+Технологийн интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 13 хувь | 12 хувь |
| 6 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир, эрүүл мэнд (6-9) | Биеийн тамир+Эрүүл мэндийн интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 8 хувь | 7 хувь |
| | Уян хатан ба сонгон судлах агуулга<br>(Уян хатан цагийн хуваарьтай заавал судлах хичээл, сонгож заавал судлах хичээл, сургууль сонгох уян хатан хичээл Орон нутаг, сургууль, багш, сурагчийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн сонгох боломжтой уян хатан агуулгатай сургалтыг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулж болно. | | | 6 хувь | 14 хувь |

- Сонгон судлах гадаад хэл илүү олон сонголттой болох
- Хөтөлбөр боловсруулагчийн ойлголт, чадавх (интеграц хөтөлбөр...)
- Математик, технологи ... хичээлд ICT хэрэглэх орчин бүрдүүлэх
- Химийн хичээлийг 7 дугаар ангиас судлах
- Багш бэлтгэх, сургах (интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх)
- Биеийн тамир ба эрүүл мэндийг интеграц агуулгаар судлах (цагийн зохицуулалт хийх боломж: улиралд судлах нийт цагийн тодорхой хувьд нь эрүүл мэндийн агуулгаар хичээл орох...)



## *Одоо хэрэгжиж буй (Бүрэн дунд*

| № | Суралцахуйн хүрээ | Заавал судлах /хичээл (83 хувь) | Сонгон судлах/ хичээл (17 хувь) |
|---|---|---|---|
| 1 | Хэл, харилцаа | Монгол хэл (10-12)<br>Уран зохиол (10-12)<br>Үндэсний бичиг (10-12)<br>Англи хэл/орос хэл (10-12) | Монгол хэл (10-12)<br>Уран зохиол (10-12)<br>Англи хэл/орос хэл (10-12) |
| 2 | Математик | Математик (10-12) | Математик (10-12) |
| 3 | Байгалийн ухаан, | Биологи (10-11)<br>Физик (10-11)<br>Хими (10-11) | Биологи (10-12)<br>Физик (10-12)<br>Хими (10-12) |
| 4 | Нийгмийн ухаан | Газарзүй (10-11)<br>Түүх (10-11)<br>Нийгэм судлал (10-11)<br>ИЁЗБ (10-12) | Газарзүй (10-12)<br>Түүх (10-12)<br>Нийгэм судлал (10-12)<br>Бизнес судлал (10-12) |
| 5 | Технологи | Дизайн/ зураг зүй технологи (10-12)<br>Мэдээллийн технологи (10-12) | Дизайн/ зураг зүй (10-12)<br>Техник технологи (10-12)<br>Мэдээллийн технологи (10-12) |
| 6 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир (10-12)<br>Эрүүл мэнд (10-12) | - |
| Өдрийн ачаалал<br>7 цаг | | X ангид -16 хичээл<br>XI ангид- 16 хичээл<br>XII ангид- 10 хичээл | X ангид- 4 хичээл (7 хоногт 1-2 цагаар),<br>XI ангид- 3 хичээл (7 хоногт 2-3 цагаар),<br>XII ангид- 3 хичээл (7 хоногт 4-8 цагаар) |

# *Хувилбарт хамаарах хичээл (Бүрэн дунд боловсрол)*

| № | Суралцахуйн хүрээ | Заавал судлах хичээл | Сонгон судлах/ хичээл | Чөлөөт сонголтын хичээл |
|---|---|---|---|---|
| 1 | Хэл, харилцаа | Монгол хэл, уран зохиол (10-12)<br>Анхдагч гадаад хэл (10-12) | - Монгол хэл (10-12)<br>- Уран зохиол (10-12)<br>- Үндэсний бичиг (10-12)<br>- Анхдагч гадаад хэл (10-12) | Сонгон судлах гадаад хэл (10-12) |
| 2 | Математик | Математик (10-12) | Математик (10-12) | |
| 3 | Байгалийн ухаан, | Биологи (10)<br>Физик (10)<br>Хими (10) *Жич: 11-12 ангид аль нэг хичээлийг заавал сонгон судална.* | - Биологи (10-12)<br>- Физик (10-12)<br>- Хими (10-12) | |
| 4 | Нийгмийн ухаан | Газарзүй (10)<br>Түүх (10)<br>ИЁЗБ/нийгэм судлал (10)<br>*Жич: 11-12 ангид аль нэг хичээлийг заавал сонгон судална.* | - Газарзүй (10-12)<br>- Түүх (10-12)<br>- Нийгэм судлал (10-12)<br>- Бизнес судлал (10-12) | |
| 5 | Технологи | Дизайн технологи (10)<br>Мэдээллийн технологи (10)<br><br>*Жич: 11-12 ангид аль нэг хичээлийг заавал сонгон судална.* | Дизайн технологи (10-12)<br>- Зураг зүй<br>- Дизайн технологи<br>- Техник технологи<br>Мэдээллийн технологи (10-12)<br>- Программ хангамж<br>- Техник хангамж | |
| 6 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир, эрүүл мэнд (10-12) | | Спорт тоглоом<br>Спортын бусад төрөл |
| 7 | Урлаг | | | Дүрслэх урлаг, Медиа урлаг, Хөгжим, Бүжиг, Жүжиг |
| Өдрийн ачаалал 7 цаг | | Заавал судлах хичээлийг 7 хоногт 2 цагаар судална.<br>- 10 ангид 12 хичээл<br>- 11-12 ангид 7 хичээл | X ангид 4 хичээлийг 7 хоногт 2 цагаар,<br>XI-XII ангид 3 хичээлийг 7 хоногт 4-6 цагаар, | |
| Уян хатан цагийн хуваарьтай заавал судлах хичээл, сонгож заавал судлах хичээл, сургууль сонгох уян хатан хичээл Орон нутаг, сургууль, багш, сурагчийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн сонгох боломжтой уян хатан агуулгатай сургалтыг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулж болно. 10-12 дугаар ангид 3 цагаар (7) | | | | |

# Сургалтын цагийн тооцоолол (бага, суурь боловсрол)

| Бага боловсролын сургалтын цаг | | | | |
|---|---|---|---|---|
| | Жилд хичээллэх 7 хоног | Суурь боловсролын нийт цаг | Долоо хоногийн дундаж ачаалал | Нэг өдрийн дундаж ачаалал |
| Монгол улс /одоо/ | 32 | 3905 | 24.4 | 4.9 |
| OECD дундаж | 37.2 | 4048 | 21.8 | 4.4 |
| Санал болгож буй хувилбар | 33 | 4052 | 24.5 | 4.9 |

| Суурь боловсролын сургалтын цаг | | | | |
|---|---|---|---|---|
| | Жилд хичээллэх 7 хоног | Суурь боловсролын нийт цаг | Долоо хоногийн дундаж ачаалал | Нэг өдрийн дундаж ачаалал |
| Монгол улс /одоо/ | 33 | 4690 | 35.5 | 7.1 |
| OECD дундаж | 36.8 | 3631 | 24.7 | 4.5 |
| | | | | |

**Бага боловсролын сургалтын цаг**

| | | | А/491 (32 долоо хоног) | | | OECD (37.2 долоо хоног) | | | Санал болгож буй хувилбар (33 долоо хоног) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хувь | Нийт цаг | 7 хоногт | Хувь | Нийт цаг | 7 хоногт | Хувь | Нийт цаг | 7 хоногт |
| 1 | Хэл, харилцаа | Монгол хэл (1-5) | 30 | 1088 | 7 | 32 | 1296 | 7 | 32 | 1056 | 6-7. |
| | | Анхдагч гадаад хэл (3-5) | | 96 | 3 | | | | | 257 | 2-3. |
| 2 | Математик | Математик (1-5) | 19 | 752 | 4-5. | 17 | 688 | 3-4. | 17 | 726 | 4-5. |
| 3 | Байгалийн ухаан | Байгалийн ухааны хичээл (1-5) | 6 | 224 | 1-2. | 8 | 324 | 1-2. | 8 | 264 | 1-2. |
| 4 | Нийгмийн ухаан | Ёс зүйн боловсрол+Нийгмийн ухаан (1-5) | 13 | 512 | 3-4. | 11 | 446 | 2-3. | 11 | 462 | 2-3. |
| 5 | Урлаг, Технологи, ICT | Хөгжим (1-5)<br>Дүрслэх урлаг, технологи (1-5)<br>ICT (2 хувилбар) | 15 | 596 | 3-4. | 13 | 526 | 2-3. | 15 | 627 | 3-4. |
| 6 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир, эрүүл мэнд (1-5) | 10 | 378 | 2-3. | 9 | 364 | 1-2. | 9 | 396 | 2-3. |
| Цагийн зохицуулалтыг сургууль өөрөө хийх боломжтой, Үндэсний сургалтын хөтөлбөрт нийцсэн<br>Орон нутаг санал болгосон<br>Сургуулиас сонгосон заавал судлах хичээл байх | | | 5 | 199 | 1-2. | 10 | 404 | 2 | 8 | 264 | 1-2. |
| Бусад | | | 2 | 60 | | | | | | | |
| Нийт, хувь, цаг | | | 100 | 3905 | | 100 | 4048 | | 100 | 4052 | |

**Суурь боловсролын сургалтын цаг**

| № | Суралцахуйн хүрээ | Хичээл | А/491 (33 долоо хоног) | | | OECD (36.8 долоо хоног) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хувь | Нийт цаг | 7 хоногт | Хувь | Нийт цаг | 7 хоногт |
| 1 | Хэл, харилцаа | Монгол хэл (6-9)<br>Уран зохиол (6-9)<br>Үндэсний бичиг (6-9)<br>Анхдагч гадаад хэл (6-9)<br>Сонгон судлах гадаад хэл (8-9) | 31 | 1452 | 11 | 30 | 1089 | 7-8 |
| 2 | Математик | Математик (6-9) | 12 | 561 | 4-5. | 12 | 436 | 3.0 |
| 3 | Байгалийн ухаан | Биологи (6-9)<br>Физик (6-9)<br>Хими (7,8-9) | 15 | 693 | 5-6. | 12 | 436 | 3 |
| 4 | Нийгмийн ухаан | Түүх (6-9)<br>Ёс зүйн боловсрол+Нийгэм судлал (8-9)<br>Газарзүй (7-8) | 15 | 693 | 5-6. | 14 | 508 | 3-4 |
| 5 | Урлаг, технологи, ICT | Дүрслэх урлаг (6-8)<br>Хөгжим (6-9)<br>Дизайн технологи (зураг зүй, технологи) (6-9)<br>Мэдээллийн технологи (6-9) | 13 | 627 | 4-5. | 12 | 436 | 3 |
| 6 | Биеийн тамир, эрүүл мэнд | Биеийн тамир, эрүүл мэнд (6-9) | 8 | 396 | 3 | 8 | 290 | 2 |
| 7 | Уян хатан ба сонгон судлах агуулга<br>(Уян хатан цагийн хуваарьтай заавал судлах хичээл, сонгож заавал судлах хичээл, сургууль сонгох уян хатан хичээл Орон нутаг, сургууль, багш, сурагчийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн сонгох боломжтой уян хатан агуулгатай сургалтыг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулж болно. | | 6 | 268 | 2 | 12 | 436 | 3 |
| | | | 100 | 4690 | | 100 | 3631 | |

# *Бага боловсролын хичээл, тоо (санал болгож буй хувилбар)*

Бага боловсролын тухайд

| А/491 | | | | | II хувилбар | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| I | II | III | IV | V | I | II | III | IV | V |
| Бэлтгэл | | | | | Бэлтгэл | | | | |
| Монгол хэл | | | | | Монгол хэл | | | | |
| | | | | А/х | | | Англи хэл | | |
| Математик | | | | | Математик | | | | |
| Хүн/о | | | | | | | | | |
| | | | Хүн/б | | Байгалийн ухаан | | | | |
| | | | Хүн/н | | Ёс зүйн боловсрол+НУ | | | | |
| ИЁЗБ | | | | | | | | | |
| Дүрслэх урлаг, технологи | | | | | Дүрслэх урлаг, технологи | | | | |
| Хөгжим | | | | | Хөгжим | | | | |
| | | | | | ICT | | ICT | | |
| Биеийн тамир | | | | | Биеийн тамир, эрүүл мэнд | | | | |
| | | | э/м | | | | | | |

| Боловсролын түвшин | Үе шат | Хичээлийн тоо | |
|---|---|---|---|
| | | Одоо мөрдөж байгаа | Санал болгож буй хувилбар |
| Бага боловсрол | Эхэн үе (1-2 дугаар анги) | 7-10 | 8 |
| | Төгсгөл үе (4-5 дугаар анги) | 9-10. | 9 |
| Суурь боловсрол | Эхэн үе (6-7 дугаар анги) | 16-19 | 16 |
| | Төгсгөл үе (8-9 дүгээр анги) | 19 | 16 |
| Бүрэн дунд боловсрол | | 11-16. | 7+1-12 |

## Хөтөлбөр боловсруулах

-Судалгаа (гадаад улс орны туршлага судлах ... Интеграц хөтөлбөрийг хэрхэн боловсруулах)
-Хүний нөөцийг чадавхжуулах (Хөтөлбөр боловсруулагчийг чадавхжуулах, мэдээллээр хангах)

## Сургалтын орчин бүрдүүлэх

-Бага ангид ICT-ийн хичээлд шаардлагатай орчин бүрдүүлэх
-Математик, технологийн хичээлд ICT хэрэглэх боломж бий болгох
-Бага төдийгүй бүх ангид англи хэлний зориулалтын танхим байгуулах

## Багш бэлтгэх, давтан сургах

-Бага ангид англи хэл заах багш бэлтгэх, сургах...
-Бага ангид ICT-ийн хичээл заах багш бэлтгэх, сургах ...
-Интеграц хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийг сургах, чадавхжуулах...

# Хичээлийн хөтөлбөр

Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын ….. хэсэгт судлахаар тодорхойлсон хичээл бүрээр сургалтын хөтөлбөр боловсруулна. Хичээлийн хөтөлбөр нь судлах агуулга, эзэмших мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлс болон тэдгээрийг хөгжүүлэх, үнэлэх арга зүйг заасан байна. Хичээлийн хөтөлбөр нь анги, түвшин бүрт хамаарах суралцахуйн зорилтуудыг үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалтай уялдуулан томъёолсон байх ба хүлээгдэж буй суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна. Хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад дараах ерөнхий чиглэлийг баримтална.

- Хичээлийн хөтөлбөрт анги, түвшин бүрт суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл зэрэг суралцахуйн үр дүнг дэлгэрэнгүй тайлбарласан байх,
- Агуулга нь шинжлэх ухаанд үндэслэсэн, практик үйлд баримжаалсан, нийгмийн ач холбогдолтой, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан үндэсний болон орон нутгийн онцлог, уламжлалыг тусгасан байх;
- Хичээл бүрийн агуулгыг чадамжийн хүрээтэй уялдуулж, интеграцчилсан байх;
- Суралцахуйн үр дүнг цогц, хэмжигдэхүйц байдлаар харуулах зорилготой үнэлгээний шалгууртай байх;
- Хувь хүний ялгаатай байдал, хөгжлийн онцлог, суралцахуйн хэв маягт тохирсон байх;
- Орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилсан, цахим хэлбэрээр сургалт явуулах боломжтой байх;
- Суралцагчдыг тэгш хамруулах, тэдний соёлын ялгаатай байдлыг харгалзан үзсэн, жэндерийн тэгш байдлыг харгалзсан байх;
- Суралцагчдын нас, сэтгэхүй, боловсролын түвшний ялгаатай байдлыг харгалзсан байх;
- - Суралцагч цахим сургалтын хэлбэрийг ашиглан гар утас болон таблетаар дамжин цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бие даан судлах боломжийг харгалзсан байх;

# СУРАХ БИЧГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

**Сурах бичгийн агуулга, арга зүй, үнэлгээг чадамжийн хүрээтэй уялдуулж, интеграцчлах**

Суралцагч бүтээлч, шүүн тунгаах сэтгэхүйтэй, суралцахуйд суралцах, хамтран ажиллах, харилцах, сэтгэл хөдлөлөө зохицуулах, дижитал бичиг үсгийн ур чадвартай, хариуцлагатай, дэлхийн болон үндэсний өв соёлын чадамжийг сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ, орчинд тусгасан байгааг хичээл судлагдахуун бүрээр анги, түвшин бүрийн сурах бичгийн хамаарах сэдэв агуулгад ахиц, дэс дараа, залгамж холбоотойгоор ойлгомжтой жишээ баримтаар тусган боловсруулна.

**Сургалтын хөтөлбөрт туссан үндэсний үнэт зүйлийг судлагдахууны онцлогтойгоор сурах бичигт тусгах**

Сургалтын хөтөлбөрт суралцагч бүр мэдэж, бүх нийтээр эрхэмлэх үнэт зүйлийг тусгаж, анги, түвшин агуулга, сэдэв бүрд хувь хүн, гэр бүл, бусдаас олж авах үнэт зүйл, үндэсний болон хүн төрөлхтний үнэт зүйлийг хичээл судлагдахууны онцлогт тулгуурлан сурах бичгийн агуулга, арга зүйд, үнэлгээ, дизайнд тусгана.

**Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзах, сурлагын ахиц, амжилтыг дэмжих**

Сурах бичгийн бүтэц дизайн ажиллах талбар нь ойлгомжтой жишээ зааварчилга, аргачлал боловсруулан дээд эрэмбийн мэдлэг, танин мэдэхүй, хөдөлгөөний ур, эерэг хандлага төлөвшүүлэхэд, чиглэсэн шийдэлтэй, орчин үеийн дэвшилтэт, арга зүйд үндэслэн агуулга, арга зүй, үнэлгээ, дизайныг боловсруулна. Сурах бичиг нь суралцагчдын нас, сэтгэхүй, боловсролын түвшний ялгаатай байдлыг харгалзсан таатай эерэг сэтгэгдэл төрүүлсэн, ойлгомжтой, сонирхолтой байна.

**Суралцагч хэрэгцээ, сонирхолдоо нийцсэн сурах бичгийг сонгож хэрэглэх**

ЕБС-ийн бага, дунд боловсролын сурах бичиг нь суралцагчдын (тэгш хамруулах сургалт) ялгаатай хэрэгцээнд суурилсан нас сэтгэхүйн онцлогт нийцсэн сурагчийн, дасгал ажлын, багшийн, электрон, аудио, видео зэрэг олон хэлбэрийн бүтээгдэхүүнийг багтаасан цогц шинжтэй, нээлтэй хэрэглэгдэхүүн байна. Байгалийн ухаан, урлаг, гоо зүйн, мэдээллийн технологийн сурах бичиг нь суралцагчийн хэрэгцээ сонирхолыг татсан, олон нийтийн оролцоо, нээлттэй байдлыг эрхэмлэнэ.

**Орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилсан, сургалтыг дэмжсэн цахим сурах бичгийн хэрэглээг дэмжих**

Цахим сурах бичгийг ашиглан гар утас болон таблетаар дамжин цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бие даан судлах боломжийг бүрдүүлэх агуулга нь шинэлэг, сурагчийн амьдрал, хөгжилд ач холбогдолтой, шаардлагатай чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

**Сурах бичгийн агуулга, арга зүй, дизайныг боловсронгуй болгох, чанаржуулах**

Сурах бичгийн агуулга, арга зүй дасгал даалгавар нь бодит амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх, өгөгдөл, нөхцлийн дагуу зохиох, олон аргаар бодох, шийдэлтэй, хэд хэдэн нэгж сэдвийг хамарсан цогц даалгавар байхаас гадна сурагчдын сэтгэхүйн үйлийг дэмжсэн, мэдлэг, чадвар, сурах арга барил, үнэт зүйлийг цогцоор үнэлэхэд чиглэгдсэн байна. Байгаль орчны боловсрол, иргэний ёс зүй, үнэт зүйл, эрүүл мэнд сайн сайхан байдал, соёлын олон янз байдал, мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний боловсрол, жендэрийн эрх тэгш байдал, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох боловсролыг эзэмших, төлөвшүүлэхэд чиглэсэн суралцахуйн үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн байна.

# Сургалтын орчин

Цэцэрлэг, сургуулийн анги, танхим нь хичээл, сургалтын үйл ажиллагааны бүх загварт тохирсон нэг төрлийн хэмжээ загвар гэдэг ойлголтоос багшлахуй ба суралцахуйн таатай нөхцлийг дэмжсэн шинэ загварыг өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн тодорхойлж байна. Сургалтын хөтөлбөрийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хөгжүүлэх олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулах,  орон зай, сурагчдын тоо, суудал зохион байгуулалт, интернэт зэргийг тусгайлан анхаарах шаардлагатай. Үүнд:

- Нэг багшид ноогдох сурагчийн тоог цэцэрлэгт 1:25, 1 дүгээр ангид 1:30, бусад ангиудад 1:35-аас хэтрүүлэхгүй байх
- Ангийн тавилга, ширээ сандлын байрлал, зохион байгуулалтын сонголтоос эхлээд төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах, суралцахуйг зугаатай болгоход зориулсан, ая тухтай орчин бүрдүүлэх
- Бодит асуудалд суурилсан утга учиртай суралцахуйд чиглэх
- Олон хэл, технологи ашиглаж суралцах боломжийг олгох
- Суралцахуйг үр өгөөжтэй таатай болгохын өрөөний температур, агаарын чанар, гэрэл, дуу шуугиан, үнэр зэргийг сурахад тааламжтай  орчинг бүрдүүлэх
- Суудал зохион байгуулалт нь багийн ажил зохион байгуулахад хүндрэл учруулахгүй байхаар зохион байгуулах
- Хүүхэд хөгжүүлэх төрөл бүрийн булан, ангийн номын сан, тоглоом, жижиг сажиг материал хэрэгслийн цуглуулга зэрэг нь суралцагчид олон хэлбэрийн хөгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжоор хангах
- Анги танхимыг дараах байдлаар нэмж тохижуулан өндөр хурдны интернет орчин бүхий сууж, босоход амар орон зай, тухалж суух боломжтой орчин, туршилт хийх багаж хэрэгсэл бүхий өрөө танхимтай бий болгох
- Хичээл бүрийн онцлогоос хамаарч сургалтын орчин ялгаатай байна. Бүх түвшин ангийн суралцагчдад хүртээмжтэй биеийн тамирын хичээлийн хэрэгсэл, байгалийн ухаан, урлаг, уран зураг зэрэг хичээлүүдэд зориулсан тусгай танхимтай болох
- Бүх сургуулиудыг компьютерийн лаборатори, утасгүй интернэтийн сүлжээгээр хангах, анги танхим бүрийг зөөврийн болон суурин компьютер, проектор, ухаалаг самбар, таблетаар хангах, хүртээмжтэй болгоход анхаарах
- Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдад зориулсан тусгай технологийн нөөц, дэмжих технологийг өдөр тутам ашиглах боломжтой, хүртээмжтэй байхаар зохион байгуулах

# Хичээл хоорондын агуулга

Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд судлагдахуун хоорондын нийтлэг агуулгыг судлах нь улс үндэстний ирээдүйн асуудлуудыг шийдвэрлэх, суралцахуйн хүрээ болон үнэт зүйлсийн хоорондын холбоо хамаарлыг бий болгож суурь чадамжийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн судлагдахуун хоорондын агуулга нь суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг хөгжүүлэхийн зэрэгцээ уялдаа холбоо бүхий агуулгаар дамжуулан сурах сэдлийг бий болгодог.

Дараах судлагдахуун хоорондын агуулгыг сургалтын хөтөлбөрт зайлшгүй тусган эзэмшүүлэх шаардлагатай нийтлэг агуулга гэж үзэж байна.  Үүнд:

- **Байгаль орчны боловсрол**
- **Иргэний ёс зүй, үнэт зүйл**
- **Эрүүл мэнд, сайн сайхан байдал**
- **Соёлын олон янз байдал**
- **Мэдээлэл харилцаа технологийн хэрэглээний боловсрол**
- **Жендэрийн эрх тэгш байдал**
- **Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох боловсрол**

**(Боловсролын ерөнхий хуулийн төсөл, OECD-2030, бусад судалгааны үр дүнг эш болгов.)**

# Багшлахуй ба суралцахуй

Үндэсний сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл санаа, зорилтыг өдөр тутмын хичээл сургалтын үйл ажиллагаагаар хэрэгжүүлэхийн тулд багшлахуйн арга стратегид шинэчлэл хийх хэрэгтэй болж байна. Сурагчдын дуу хоолойг хүндэтгэх, оролцоонд суурилах, мэдлэг хамтран бүтээх, мэдлэгээ хуваалцах, интерактив үйлээр суралцах орчин үеийн идэвхтэй суралцахуйн аргуудыг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нэвтрүүлэх замаар арга зүйг арвижуулах шаардлага буй болов. Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал нь багшлахуйн арга стратегийн хувьд дараах шилжилтийг чухалчилж байна. Үүнд:

- Багшлахуйгаас илүүтэй суралцахуйд чиглэх
- Өрсөлдөхөөс илүүтэй хамтрахад чиглэх
- Судалсан агуулгыг цээжлэх, давтан ярих, бичиж, тэмдэглэхээс илүүтэй өмнөх мэдлэг дээрээ суурилсан шинэ мэдлэг бүтээхэд чиглэх
- Бодит асуудалд суурилсан утга учиртай суралцахуйд чиглэх
- Олон хэл, технологи ашиглаж суралцах боломжийг олгох
- Сурагчийг сурах үйлд сонирхол, хүсэл тэмүүлэлтэй болгох, ирээдүйд эзэмших ажил мэргэжил, амьдрал ахуйтайгаа өнөөгийн суралцахуйгаа холбон, өөрийн сурах үйлийн агуулгыг шинжлэн дараачийн алхамтайгаа холбох чадвартай болоход чиглэх.
- Сурагчид хоорондоо болон багш, иргэдтэй хамтран ажиллах замаар өмнөх үеийнхний сайн туршлага, үндэсний уламжлалт сэтгэлгээний өвөөс санаа авч өөрийн сэтгэх чадварыг өргөжүүлэн гүнзгийрүүлэх чадвартай болоход чиглэх
- Мэдлэг бүтээх, чадвар эзэмших, эзэмшсэн мэдлэг, чадвараа хэрэглэх, гүнзгийрүүлэн шинжлэн судлах зэрэг суралцах үйлийн явцдаа тухайн судлагдахууны онцлогт нийцсэн сэтгэлгээний арга барилаар, мэдлэгийг уялдаа холбоонд нь зангидан гүнзгий ойлгох, мэдээллийг нягтлан санаа бодлоо цэгцлэх, асуудлыг эрж хайн шийдвэрлэх арга замыг олох, бүтээлчээр сэтгэх чадвар эзэмшүүлэхэд чиглэх

Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал нь багшлахуйн арга стратегийн хувьд тэгш хамруулах үзэл санаанд үндэслэнэ. Тэгш хамруулах үзэл санаанд суурилсан багшлахуйн арга стратеги нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд:

- Тэгш хамруулах
- Ялгаатай байдлыг харгалзах
- Хоорондоо уялдаа холбоотой байх
- Иргэд олон нийтийн оролцоог хангах

# Тэгш хамруулах боловсрол

Тэгш хамруулах боловсрол нь ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан, суралцагчийн харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, хэл соёлын ялгаатай байдал, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд хүртээмжтэй, чанартай боловсрол олгоход чиглэгдсэн тасралтгүй үйл явц юм. Тэгш хамруулах боловсрол нь бүх нийтийн боловсролд тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх, суралцагчийн харилцан адилгүй, ялгаатай хэрэгцээг  хүлээн зөвшөөрөхөд боловсролын бодлого, үйл ажиллагаа, практикийг чиглүүлнэ. Тэгш хамруулах боловсролд тусгай хэрэгцээтэй суралцагчийг хамруулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Суралцагчийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, аливаа ялгаварлан гадуурхалтгүй, тэгш,  хүртээмжтэй байх;
- Суралцагчид эрт үеийн хөгжлийн үнэлгээ хийх, тулгарч буй суралцахуйн сорилт, хэрэгцээг тодорхойлох;
- Суралцагчийн ялгаатай байдлыг харгалзан хөгжих, суралцах, дасан зохицоход нь туслах боловсролын дэмжлэгийн үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх;
- Суралцагчийн ялгаатай хэрэгцээ, хэл соёлын ялгаатай байдал, сонирхол, чадварт суурилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багшлах арга зүйд болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүний тохируулга хийх, ахиц, өөрчлөлтийг үнэлэх боломжийг бүрдүүлэх;
- Боловсрол нийгмийн дасан зохицох чиглэлийг удирдлага болгож, суралцагчийн хөгжлийн бэрхшээлийг засах нь эцсийн зорилго биш, харин тухайн суралцагч нийгмийн амьдралд бие даасан хараат бус байдлаар оролцож сурах боломжоор хангахад чиглэх;

# Тэгш хамруулах боловсрол

Тэгш хамруулах сургалтын хөтөлбөрт үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээнд боловсролын түвшин бүрд суралцагчийн давуу тал, суралцахуйн ялгаатай хэрэгцээ, хэл соёлын ялгаатай байдал, сонирхол, саналыг үндэслэн тохируулга хийж, сонголттой байх боломжийг олгож болно. Үүнд:

- Үндэсний сургалтын хөтөлбөр: (зарим суралцагчийн хувьд үндэсний сургалтын хөтөлбөрөөр өөрчлөлт, тохируулгагүйгээр суралцах чадвартай байдаг).
- Үндэсний сургалтын хөтөлбөрт бага зэрэг өөрчлөлт хийсэн сургалтын хөтөлбөр: (зарим суралцагч жирийн хөтөлбөрийн дагуу ч зарим нэг зүйлийг нь өөрчлөөд суралцах боломжтой байдаг. Энэ үед анги, боловсролын түвшинд хамаарах суралцахуйн үр дүнг өөрчлөхгүй. Суралцагчийг суралцах боломжоор хангахын тулд ямар төрлийн өөрчлөлт оруулах шаардлагатайг суралцагчид зориулсан Тусгайлсан Сургалтын Төлөвлөгөөнд тодорхойлсон байна).
- Суралцахуйн үр дүнг өөрчилсөн (өөрчлөлттэй, өөрчлөлтгүй) жирийн хөтөлбөр: (зарим суралцагчийн хувьд жирийн сургуулийн аль нэг түвшний хөтөлбөрөөр сургах, гэхдээ суралцахуйн үр дүнг нь бага зэрэг ялгаатайгаар тохируулж өгнө ( суралцахуйн үр дүнгийн тоо хэмжээ, цогц байдлыг өөрөөр зааж өгөх зэргээр).  Суралцахуйн үр дүнг өөрчилж тохируулахдаа тусгай мэдлэг, чадварыг тодорхойлсон, бодитой, ажиглагдахуйц, мөн хэмжигдэхүйц байхад анхаарна).
- Үндэсний сургалтын хөтөлбөрийг эсвэл бага зэрэг өөрчилсөн хөтөлбөрийг суралцахуйн үр дүнг ялгаатайгаар тодорхойлсон тусгай хөтөлбөр: (жирийн хөтөлбөрт үндэслээгүй)-тэй хослуулах (үндэсний сургалтын хөтөлбөрийг эсвэл бага зэрэг өөрчилсөн хөтөлбөрийг суралцахуйн үр дүнг ялгаатайгаар тодорхойлсон тусгай хөтөлбөр (үндэсний сургалтын хөтөлбөрт үндэслээгүй)-тэй хослуулах: (зарим суралцагчийн хувьд ердийн сургуулийн хөтөлбөрт тусгагддаггүй мэдлэг, чадварыг олж авахад нь туслахуйц хөтөлбөрийг боловсруулна. Энэхүү хөтөлбөр нь амьдрах чадвар болон бусадтай харилцах чадвар, хөдөлгөөний сургалт, бусдын туслалцаагүй өөрийгөө аваад явах зэрэг чадварыг тусгана).

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр (хувь хүүхдийн ялгаатай хэрэгцээ, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багшийн зөвшилцсөнөөр боловсруулж, хэрэгжүүлнэ).

# Тэгш хамруулах боловсрол

Тэгш хамруулах сургалтын хөтөлбөрт тохируулга хийх хувилбарууд:
**Орц:** Хичээл заах, сургах стратегийг тохируулан өөрчлөх. Жишээ нь: Өөр өөр үзүүлэн материал, бодит жишээ, гараар хийх үйлдэл даалгавар, хамтарсан суралцахуйн аргыг ашиглах гэх мэт.
**Гарц:** Суралцагчаас хариу сонсох, хүлээж авах аргыг ялгаатай болгох. Жишээ нь: Хариултыг амаар эсвэл бичгээр хүлээж авах, мэдлэгийг шалгахдаа уламжлалт хэлбэрийн асуулт/хариултын оронд гараар хийсэн материалыг ашиглах, гэх мэт.
**Хугацаа:** Суралцахуй болон даалгавар гүйцэтгэхэд шаардагддаг цагийг ялгаатай болгох. Жишээ нь: суралцахуйн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн суралцахуйн хурдад тохирсон хугацаа өгөх (ихэсгэх, багасгах), шалгалтын үед илүү урт хугацаа өгөх гэх мэт.
**Даалгаврын түвшин:** Даалгаврын түвшин болоод даалгавар гүйцэтгэх дүрмийг ялгаатай болгох. Жишээ нь: Даалгаврын зааврыг хялбарчлах, математикийн зарим нэг даалгаварт тооны машин ашиглахыг зөвшөөрөх зэргээр суралцагчийн хэрэгцээнд тохируулан дүрмийг өөрчлөх.
**Дэмжлэг үзүүлэх түвшин:** Суралцагчийг асрах, туслахад зориулан дэмжлэгийн түвшинг ялгаатай болгох. Жишээ нь: Суралцагчийн хэрэгцээ шаардлагаас хамааран хамтрагч багш, туслах багш ажиллуулах гэх мэт.
**Тоо хэмжээ:** Суралцагчийн сурах зүйл, гүйцэтгэх даалгаврын тоо хэмжээг ялгаатай болгох. Жишээ нь: Нэг удаад суралцагчийн авах ёстой оноо, сурах ёстой агуулгын тоог багасгах.
**Оролцооны түвшинг өөрчлөх:** Суралцагчийн даалгаварт идэвхитэй оролцох хэлбэрийг ялгаатай болгох. Жишээ нь: Газарзүйн хичээл дээр хүүхдүүд дэлхийн бөмбөрцөг дээр байршил зааж байх үед тусгай хэрэгцээт суралцагч бөмбөрцөгийг барьж байх зэрэг.
**Ялгаатай зорилт дэвшүүлэх:** Адилхан сургалтын материал ашиглах ч суралцахуйн зорилт, зорилго, хүрэх үр дүнг өөр байхаар тохируулах. Жишээ нь: Газарзүйн хичээл дээр зарим суралцагч дүүргүүдийг нэрлэж байхад зарим нь байршлыг нь олох зэрэг.
**Орлуулах хөтөлбөр**: Суралцагчийн тусгай зорилтод нийцсэн өөр хичээл, заах арга, материалын сонголтыг бий болгох. Жишээ нь: Суралцагчийн хэрэгцээнд тохируулан Нэмэлт эсвэл Ганцаарчилсан хөтөлбөрөөр хангах.

# Тэгш хамруулах боловсрол

*Хөтөлбөрт тохируулга хийх үйл явц*

1. Суралцагчийн суралцах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх (Суралцах үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлох)
2. Тодорхой суралцахуйн үр дүнг зааж өгөх
3. Ямар агуулга, сэдэв, хүрээ, үйл ажиллагаа байхыг шийдэх
4. Суралцагч хүлээсэн үр дүнд хүрэхэд нь туслахын тулд жирийн хичээлийн арга зүйд өөрчлөлт, зохицуулалт хийх шаардлагатай эсэхийг тогтоох
5. Хэрхэн өөрчлөх, тохируулах талаар сонголт хийх

Тухайн хичээлд хамаатай хөтөлбөрийн зорилтыг сонгох
Бие бялдарын хувьд болон бусадтай харилцах харилцааны явцад шинэ зүйлд суралцах орчин бүрдүүлэх
Хичээл заах төлөвлөгөө, дэс дараагаа сонгох
Хичээлийн хэлбэрээ сонгох
Суралцагчид тусгайлан зориулсан заах аргыг ашиглах
Хичээлийн материалаа өөрчлөх
Суралцахуйн дэмжлэг, ажиглалт хяналтын тохиромжтой хэлбэрийг сонгох

6. Хийсэн өөрчлөлт, тохируулгын үр дүнг хэмжих

Шаардлагатай үед дахин өөр үйл ажиллагаа төлөвлөх, боловсруулах

7. Өөрчлөн тохируулсан аргын нийт үр дүнг үнэлэх

Тэгш хамруулах сургалтын хөтөлбөрийн сонголтод олон талын оролцоо, эрх үүргийг тусган, сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлт дэх орон нутгийн уян хатан байдлыг бодлогоор дэмжихэд анхаарна.

# Тэгш хамруулах боловсрол

Тэгш хамруулах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зохион байгуулалтыг хийнэ. Үүнд:
- Цэцэрлэг, сургуулиуд суралцагчийг ердийн сургуульд орчин нөхцлөөс хамаарсан бэрхшээлгүйгээр хамруулан сургахын тулд шаардлагатай тоног төхөөрөмж, тохирох хэрэгсэл бүхий сургалтын орчныг бүрдүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн суралцахуйн арга барилд тохирох багшлах стратегийг хэрэгжүүлнэ. Тэгш хамруулах багшийн арга зүйг цогц шинжтэй нийгмийн түвшинд, сургуулийн түвшинд, анги бүлгийн түвшинд хөгжүүлнэ.
- Үнэлгээний хэлбэр нь ажиглалт хийх, ажиглах явцад анзаарагдсан зүйлсээ тусгайлан боловсруулсан жагсаалтад тэмдэглэх, ямар чадвар нь илүү хөгжсөн, ахиц, амжилттай байгаа талаарх үйл явцыг тэмдэглэж баталгаажуулна.
- Суралцагчийн тусгай сургуулиас ердийн сургуульд элсэх, ердийн сургуулиас тусгай сургуульд шилжин суралцах нөхцөлөөр хангана.
- Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэр, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчийн хүсэлтийг харгалзан тухайн суралцагч тусгай сургуульд эсвэл ердийн сургуульд суралцана.
- Тодорхой хугацаанд тусгай хэрэгцээт сургуульд сурсан суралцагчийг мэргэжлийн баг боломжтой гэж үзсэн тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч, суралцагчийн зөвшөөрлөөр ердийн  сургуульд шилжүүлж болно.
- Тусгай хэрэгцээт боловсролын багш, дэмжих багш, сэтгэл зүйч, хэл засалч бусад мэргэжлийн хүмүүс бүхий боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ажилтнууд, орон нутаг, эцэг эх, асран хамгаалагч,  иргэд, олон нийттэй хамтарч ажиллана.

# Дэмжих хөтөлбөр

Сурлагын хоцрогдолтой сурагчид нэмэлт хичээл, арга зүйн дэмжлэг үзүүлж үеийн сурагчдын хүрсэн түвшинд хүргэхэд нь дэмжих үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр гэж ойлгоно. Сургуулиуд анги, түвшин бүрт хамаарах хоцрогдол арилгах системийг албан ёсоор нэвтрүүлэх шаардлагатай ба ингэснээр суралцагчийн хэрэгцээ шаардлага, түвшинд нь тохирсон суралцахуйн дэмжлэг үзүүлж, суралцахуйн үр дүнгээ ахиулах боломж олгоно. Түүнчлэн сургууль бүр хоцрогдол арилгах, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн багштай байх шаардлага үүсч байгааг тодотгож байна. Хичээлийн болон анги хариуцсан багш ганцаараа шийдэх боломжгүй суралцахуйн бэрхшээл үүссэн тохиолдолд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн багштай хамтран шийдвэрлэнэ. Дэмжих хөтөлбөрийн хүрээнд:

- Хоцрогдол үүссэн шалтгааныг оношлох
- Тусгайлсан болон ялгаатай байдлыг харгалзсан арга зүйг ашиглах
- Нийтлэг бэрхшээл болон зөвхөн тухайн сурагчид үүссэн бэрхшээлийг хамтад нь авч үзэх
- Гарч буй ахиц өөрчлөлт, амжилтынх нь талаар сурагчид тогтмол тайлбар өгөх
- Зорьж буй суралцахуйн үр дүнг бүрэн дүүрэн эзэмшүүлэхийн тулд сурагчид хоцрогдол арилгах арга хэмжээг танхим болон цахим хэлбэрээр тогтсон хуваарийн дагуу зохион байгуулах
- Шаардлагатай тохиолдолд суралцахуйн бэрхшээлтэй сурагчдыг нэг бүлэг болгон хичээллүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

# Гэрийн даалгавар

Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд гэрийн даалгавар түүний зохистой хугацааг тусгах нь суралцагчдын сахилга бат, үнэлгээ, цагийн менежмент, сургууль эцэг хоорондын харилцаа холбоог сайжруулах, сургалтын хөтөлбөрийн агуулгыг дэмжих, бататгах, сурлагын чанараа сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой. Тиймээс тогтмол, зохистой гэрийн даалгавар нь хүүхдийн ирээдүйд оруулсан чухал хөрөнгө оруулалт гэж үздэг байна.

Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд гэрийн даалгаврын гүйцэтгэх хугацааг дараах байдлаар санал болгож байна:

| Анги | Гэрийн даалгаврын тохиромжтой хугацаа |
|---|---|
| 1-3 | 30 минут |
| 4-6 | 45 минут |
| 7-8 | 1 цаг |
| 9-11 | 1 цаг 30 минут |
| 12 | 2 цагаас ихгүй |

# Үнэлгээ

Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал нь үнэлгээний үндсэн гурван хэлбэрийг санал болгож байна. Үүнд:

***Үнэлгээг суралцахуйн нэг хэсэг болгох:*** Суралцагч өөрийн сурч байгаа байдалд дүгнэлт хийх, сурахуйн явцаа удирдах, хянах, үнэлэх үйл явц юм.
***Багшлахуй ба суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөхийн тулд үнэлэх***: Суралцахуйг цаашид дэмжих, сайжруулахын тулд суралцагчийн явц, амжилтыг үнэлэх гэж ойлгоно. Суралцагчид суралцахуйн бэрхшээлээ даван туулах тусламж дэмжлэг авахын зэрэгцээ өөрсдийн давуу болон сул талаа мэдэж авна.
***Суралцахуйн үр дүнг үнэлэх***: Сурагчийн эзэмшсэн чадамж, суралцахуйн үр дүнг мэдээлэх зорилготой хийх үнэлэх тухай юм. Энэ үнэлгээ нь тест, шалгалт хэлбэртэй байх ба суралцахуйн амжилт, үр дүнг баталгаажуулах зорилготой.

# Үнэлгээ

Үндэсний сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд суурилан үндэсний үнэлгээний зөвлөмжийг боловсруулна. Үндэсний үнэлгээний зөвлөмж нь дараах зорилготой байна. Үүнд:

- Үнэлгээний зорилтыг үндэсний сургалтын хөтөлбөрийн зорилттой уялдуулах
- Үнэлгээний үр дүнг суралцахуйг дэмжих, арга зүйн сайн туршлагыг нэвтрүүлэхэд хэрэглэх
- Сурагчийн амжилт, суралцахуйн үйл явцыг хэмжих тохиромжтой стандарт, шалгуурыг боловсруулах
- Сурагчийн олон талт хөгжил, ахиц, амжилтыг найдвартай, үнэн бодитой, шударгаар үнэлэх,
- Холимог хэлбэрийн сургалтын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, баталгаажуулах тогтолцоог бий болгох,
- Сурагч, багш, сургуулийн гүйцэтгэл, сургалтын үйл ажиллагааг үнэлэх баталгаатай, найдвартай даалгавар, асуулгын санг бүрдүүлэх,
- Сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг үнэлэх үндэсний үнэлгээний хүрээг боловсруулах
- Үнэлгээ, чанарын баталгаажуулалт нь үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн түвшин, шатлалтай байх
- Үнэлгээ, чанарын баталгаажуулалтыг Үндэсний Мэргэшлийн Хүрээтэй уялдуулах

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА